



БИДНИЙ УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫГ

УСТГАЖ БАЙНА

КАМБОЖ: ДАРХАН ЦААЗАТ ОЙ ДАХЬ ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ,
ДАРАНГУЙЛАЛ, УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ



CONFLICT AND ENVIRONMENT

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ



**ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ НЬ ХҮН БҮРТ ЭРХИЙГ НЬ ЭДЛҮҮЛЭХИЙН
ТӨЛӨӨ ХҮМҮҮСИЙН ХҮНЛЭГ СЭТГЭЛД ТУЛГУУРЛАН КАМПАНИТ
АЖИЛ ӨРНҮҮЛДЭГ 10 САЯ ХҮНИЙГ ЭГНЭЭНДЭЭ НЭГТГЭСЭН
ДЭЛХИЙ ДАЯАРХ ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫН ХӨДӨЛГӨӨН ЮМ.**

**ЭРХ БАРИГЧИД ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ, ХЭМ ХЭМЖЭЭГ
ХҮНДЭТГЭДЭГ, ХАРИУЦЛАГАА ХҮЛЭЭДЭГ, АМЛАЛТДАА ХҮРДЭГ
ДЭЛХИЙ ЕРТӨНЦИЙГ БИЙ БОЛГОХЫН ТӨЛӨӨ БИД АЖИЛЛАДАГ.**

**БИД АЛИВАА ЗАСГИЙН ГАЗАР, УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ СУРТАЛ, ЭДИЙН
ЗАСГИЙН АШИГ СОНИРХОЛ, ШАШИН ШҮТЛЭГЭЭС АНГИД БИЕ
ДААСАН, ХАРААТ БУС БӨГӨӨД ГИШҮҮД ДЭМЖИГЧДИЙНХЭЭ ХАНДИВ
ТУСЛАМЖААР САНХҮҮЖДЭГ.**

**ХҮМҮҮС ЭВ САНААНЫ НЭГДЭЛТЭЙ, ХҮМҮҮНЛЭГ ЭНЭРЭНГҮЙ
БАЙСНААР ИЛҮҮ САЙХАН НИЙГМИЙГ БИЙ БОЛГОЖ, ӨӨРЧИЛЖ
ЧАДНА ГЭДЭГТ БИД ИТГЭДЭГ.**

©Эмнести Интернэшнл 2022 он
энэ товхимол дахь контент нь Креатив Коммонс-оор
зөвшөөрөгдсөн (жинхэнэ эх хувь, худалдааны бус, хуулбарлаагүй,
олон улсын 4.0) лицензийн дагуу баталгаажуулсан болно.
<https://creativecommons.org/licenses/by-nc-nd/4.0/legalcode>

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл манай: www.amnesty.org
цахим хуудасны зөвшөөрөл хэсгээр зочлоорой.

Amnesty International Ltd
Peter Benenson House, 1 Easton Street
London WC1X 0DW, UK

Индекс: ASA 23/5183/2022
Эх хэл: Англи хэл

amnesty.org



Нүүрний зураг: Прэй Ланг дахь хууль бус мод бэлтгэл


UIN.MN
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГА

ГАЗРЫН ЗУРАГ	4
ХУРААНГУЙ	5
АРГА ЗҮЙ	7
1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	9
1.1 КАМБОЖИЙН УУГУУЛ КҮЙ ИРГЭД	9
1.2 КАМБОЖ ДАХЬ НУТГИЙН УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙН АСУУДАЛ	10
1.3 ПРЭЙ ЛАНГ, ПРЭЙ ПРЭЙЯА РОКА	11
1.4 КАМБОЖ ДАХЬ ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ	12
2. «ТЭНД БАРАГ ЮУ Ч ҮЛДСЭНГҮЙ»: КАМБОЖ ДАХЬ БАЙГАЛИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ КҮЙ ХҮМҮҮСИЙН СОЁЛ, ХҮНИЙ ЭРХЭД ЗАНАЛХИЙЛЖ БАЙНА	14
2.1 КҮЙ ХҮМҮҮСИЙН СОЁЛ, СҮСЭГ БИШРЭЛ, АМЬДРАЛД ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ	14
2.2 УЛАМЖЛАЛТ АХУЙ АМЬЖИРГААНД ҮЗҮҮЛЖ БҮЙ АЮУЛ	17
2.3 ОЙН УСТГАЛЫГ ЗАЙНААС ТАНДАН СУДЛАХ НЬ	21
2.4 ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ ДЭХ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ОРОЛЦОО	21
3. НӨХӨН СЭРГЭЭЛТ НЭРЭЭР ДАРАНГУЙЛАЛ ҮЙЛДЭЖ БАЙНА: КАМБОЖИЙН УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМ НУТГИЙН УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙГ ЗӨРЧИЖ БАЙГАА НЬ	25
4. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	32



ГАЗРЫН ЗУРАГ



БИДНИЙ УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫГ УСТГАЖ БАЙНА
КАМБОЖ: ДАРХАН ЦААЗАТ ОЙ ДАХЬ ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ,
ДАРАНГУЙЛАЛ, УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ
Эмнести Интернэшнл

ХУРААНГУЙ

2001-2020 оны хооронд Камбож улсын 2.5 сая га модон бүрхэвч устсан байна. Хууль бус мод бэлтгэл нь тус улсын үлдсэн ойн санд заналхийлэх болов. Түүнчлэн хууль бус мод бэлтгэл нь биологийн олон янз байдал, уур амьсгалд аюул учруулахаас гадна нутгийн уугуул иргэдийн соёл, хүний эрхэд ч ноцтой үр дагавар учруулж байна.

Камбожийн Куй уугуул иргэдийн соёл болон сүсэг бишрэлийн онцлог хэв шинж нь Прэй Ланг, Прэй Прэйяа Рока зэрэг тусгай хамгаалалттай ойн сан бүхий газруудтай нягт уялдаа холбоотой байдаг оршино. Эмнести Интернэшнлийн ажилтнуудтай ярилцсан Куй хүмүүс эдгээр ойг тэдний соёл, зан заншил, сүсэг бишрэлт томоохон байр суурь эзэлдэг талаар: *"Бидний эргэн тойрны ой мод бол эрүүл мэндийн минь нэг хэсэг, оюун санаанд минь шингэж, амьдрах орчин маань болдог, манай хүмүүсийн сайн сайхан байдал, нөхөрлөл, эв нэгдлийг хадгалж байдаг"* гэж хэлсэн юм.

Гэтэл, Камбожид хууль бус мод бэлтгэл хяналтаас гарч, Куй хүмүүсийн амьдралын үндсэн хэв маягт аюул учруулж байна. Энэ талаар Куй иргэдийн нэг төлөөлөл *"Энэ бол жинхэнэ эмгэнэл. Бидний соёл, уламжлал бараг бүхэлдээ үгүй болж байна, бид маш олон уламжлал, ариун дагшин газраа алдлаа"* гэж Эмнести Интернэшнлийн ярилцлагын үеэр хэлжээ.

Энэхүү тайланд Камбожийн эрх баригчдын үйл ажиллагаа Куй иргэдийн эрхийг хэрхэн зөрчиж, тэдний Прэй Ланг, Прэй Прэйяа Рока дахь ойг хамгаалах оролдлогод хэрхэн саад учруулж байгааг баримтжууллаа. Тайлангийн судалгааг Прэй Ланг болон Прэй Прэйяа Рока орчмын бүс нутгийн оршин суугч 20 идэвхтэнтэй хийсэн ярилцлагад үндэслэв. Эмнести Интернэшнлийн төлөөлөгчид ой хамгаалах үйлст оролцож байгаа Куй иргэдийн идэвхтүүдтэй хууль бус мод бэлтгэл болон Засгийн газрын хориг саад тэдний соёл, амьжиргаа, сүсэг бишрэл, ой хамгаалах чадамжид хэрхэн нөлөөлж байгаа талаар ярилцлаа.

Куй иргэдийн соёлын амьдрал, шашны итгэл үнэмшлээс гадна тэдний уламжлалт амьжиргаа нь ойн нөөцийн тогтвортой ашиглалтаас ихээхэн хамааралтай юм. Куйчуудын амьжиргааны нэг гол хэлбэр нь модны давирхайн олборлолт бөгөөд Прэй Ланг, Прэй Прэйяа Рока орчимд ургадаг тодорхой төрлийн модноос *байгалийн гаралтай эфирийн тос* хураан авах нь амьжиргаагаа залгуулах тогтвортой арга байсаар иржээ. Гэтэл, хууль бусаар мод бэлтгэгчид үйлдвэрлэлд ашиглах зорилгоор давирхайн модыг голчлон огтлох болсон нь Куй иргэдийн амьжиргаанд ихээхэн сөрөг нөлөө үзүүлэх болов. Куй иргэдийн нэг идэвхтэн: *"Ой модыг ихээр сүйтгэх боллоо, ялангуяа манай давирхайн модыг устгаж байна. Бараг бүгд давирхайн модоо алдсан"* гэжээ.

Камбож улс сүүлийн ойн бүрхэвчийнхээ 64 орчим хувийг 2011 оноос хойш алдаж хэдэн арван жилийн турш ой устгалын хэмжээгээрээ дэлхийд дээгүүрт орж байна. Эмнести Интернэшнл болон Спэйс4Гүүд (Space4Good) зайнаас тандан судлах агентлагийн дүн шинжилгээ хийсэн шинэ мэдээллээр сүүлийн хэдэн сард тусгай хамгаалалттай хоёр газрын ойг их хэмжээгээр устгасныг илрүүлжээ.

Зайнаас тандан судлах одоогийн эх сурвалжийг ашиглан хийсэн дүн шинжилгээгээр 2021 онд дээрх хоёр тусгай хамгаалалттай газрын дор хаяж 6,271 га талбайн (8,784 хөл бөмбөгийн талбайтай тэнцэх хэмжээтэй газар) ойг устгасан байна. Нэмэлт мэдээлэл авах боломжууд бий болсноор ой устгалын талаарх илүү их мэдээлэл олдох магадлалтай юм.

Тус улсын эрх бүхий албан тушаалтнууд хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлж, зохистой бодлого хэрэгжүүлэх замаар нутгийн уугуул иргэдийн эрхийг хамгаалах үүргээ биелүүлж чадахгүй байна. Гэтэл үүнээс ч дор зүйл байна. Ойн үнэт нөөцийг хамгаалах үүрэгтэй төрийн албан хаагчид эсрэгээрээ ойн устгаж ашиг олох явдал түгээмэл гарах болжээ. Камбожийн байгаль орчны яам болон цагдаагийн байгууллагад үүрлэсэн авлига нь хууль бусаар бэлтгэсэн модны худалдааг улам гааруулж, тус улсын хувьд ач холбогдол бүхий ойн сангууд устаж үгүй болох эрсдэлийг бий болжээ.

БИДНИЙ УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫГ УСТГАЖ БАЙНА

КАМБОЖ: ДАРХАН ЦААЗАТ ОЙ ДАХЬ ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ,
ДАРАНГУЙЛАЛ, УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ

Эмнести Интернэшнл

Прэй Ланг, Прэй Прэйяа Рока орчмын нутгийн иргэд Байгаль орчны яам болон орон нутгийн цагдаагийн албан хаагчид хууль бусаар бэлтгэсэн модыг худалдаалахад илэрхий оролцдог талаар байнга ярьж байв. Төрийн албан хаагчид модны наймаачдаас хахууль авсныхаа хариууд хууль бус мод бэлтгэлийг нүдээ аниад өнгөрөөдөг, мөн тусгай хамгаалалттай болон дархан цаазтай газарт мод бэлтгэхэд нь дэмжлэг үзүүлдэг талаар мэдээллээ. Орон нутгийн нэг иргэн төрийн албан хаагчдын илэрхий хууль бус үйлдэлд цөхөрч байгаагаа илэрхийлэн: *“Зам дээр мод бэлтгэгчдээс мөнгө цуглуулж зогсдог цагдаа нарыг үнэхээр гайхдаг. Яаж ийм ичгүүр сонжуургүй байж чаддаг байна аа”* гэжээ.

Хууль бус мод бэлтгэлийн талаар мэдээлэхийг оролдсон орон нутгийн идэвхтнүүд албан тушаалтнуудын эс үйлдэл, хээл хахуультай тулгарсандаа ихээхэн бухимдаж байгаагаа илэрхийлж байв. Прэй Лангийн нэг ой хамгаалагч: *“Хамгийн гол асуудал нь, эрх мэдэлтнүүд ялангуяа Байгаль орчны яамнаас ирсэн албан хаагчид зөвхөн мөнгө олох л сонирхолтой байдаг. Би яамны харъяа орон нутаг дахь салбар дээр очиж, мод бэлтгэлийн талаар мэдээлээд, гэрэл зураг болон бусад нотлох баримтуудыг өгөх гэж олон удаа оролдсон. Гэвч тэд мод бэлтгэгчдээс мөнгө авах зорилгоор л шалгадаг”* гэв.

2020 оны 2 дугаар сараас хойш Камбожийн Байгаль орчны яам орон нутгийн идэвхтнүүдийн Прэй Ланг болон Прэй Рока дахь ой хамгаалах үйл ажиллагааг дур мэдэн хориглосон нь үндэсний болон олон улсын хууль тогтоомжоор баталгаажсан эрхийг нь бүдүүлгээр зөрчсөн явдал юм. Прэй Лангийн Орон Нутгийн иргэдийн Сүлжээ /ПЛОНИС/ болон Прэй Прэйяа Рокагийн Ойн бүсийн Орон Нутгийн иргэдийн Сүлжээ /ППРОБОНИС/ зэрэг голдуу Куй уугуул иргэдээс бүрдсэн бүлгүүдийг хууль бус мод бэлтгэлээс сэргийлэх, баримтжуулах зорилгоор ойн эргүүлд оролцохыг албан хүчээр хоригложээ.

Байгаль орчны яамны албан тушаалтнууд орон нутгийн идэвхтнүүдэд тавьсан эдгээр хоригоо Камбожийн Эвсгал холбоод болон ТББ-ын тухай хууль, Тусгай хамгаалалттай газрын тухай хуулиудтай холбож тайлбарласан байна. Гэвч Эмнести Интернэшнлээс хийсэн эрх зүйн нарийвчилсан дүн шинжилгээгээр Байгаль орчны яамнаас хийсэн энэхүү тайлбар нь үндэслэлгүй бөгөөд эдгээр хориг нь байгаль орчны идэвхтнүүдийн чөлөөтэй хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхийг шууд зөрчсөн болохыг илрүүлжээ.

Үндэсний болон олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийн дагуу Камбожийн эрх баригчид нутгийн уугуул иргэдийн соёлын эрхийг хамгаалах үүрэгтэй. Тус улс уугуул иргэд өөрсдийн төрөлх газар нутагтайгаа сүсэг бишрэл өвөрмөц харилцаа холбоогоо хадгалах, дэмжих эрх болон, энэ асуудлаар ирээдүй хойч үеийнхээ өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа хадгалах талаар тодорхойлсон НҮБ-ын Нутгийн Уугуул Иргэдийн Эрхийн тухай Тунхаглалыг дэмждэг

Байгаль орчны яамнаас дур зоргоороо тогтоосон хязгаарлалт болон хууль бус мод бэлтгэлийн хавсарсан нөлөөлөл нь Куй иргэдийн амьжиргааны эх үүсвэр болсон ой ирээдүйд, цаашлаад уугуул иргэдийн хувьд тэдний соёл, амьжиргаа, хүний эрхэд үндсээр нь аюул заналхийлж байна. Прэй Прэйяа Рокагийн нэг идэвхтэний ирээдүй хойчийнхоо төлөө зовниж хэлснээр: *“Ой модоо алдаж, ашиглах боломжгүй болж байгаа нь бидний соёлыг үгүй хийж байна. Манай соёлоос бараг юу ч үлдээгүй юм шиг санагддаг боллоо. Залуу үе маань ой дахь бидний хувьд ихээхэн чухал газруудын тухай мөн Неак Тагийн тухай түүхүүдийг хэзээ ч мэдэж чадахгүй (Куй соёлд ихээхэн чухал ойн сүнсийг хэлж байна)”*.

Томоохон бизнес эрхлэгчдийн зохион байгуулалттай хууль бус мод бэлтгэл, Засгийн газрын дарангуйлал, амь нас, эрх чөлөөнд нь аюул учрах зэрэг асар их сорилттой тулгарч байгаа ч олон Куй идэвхтнүүд өвөг дээдсийнхээ ой мод, уламжлалт амьдралын хэв маягийг хамгаалахын төлөө тууштай тэмцсээр байна. Прэй Лангийн нэг идэвхтэн: *“Үлдсэн давирхайн моднуудаа хамгаалахын тулд би маш их хичээж байна, хэнээр ч тайруулахгүй. Гэхдээ Байгаль орчны яамнаас ой хамгаалах ажилд байнга саад болж байгаа учраас хүчин чармайлт гаргахад үнэхээр хэцүү байна”* гэв.

Камбожийн үлдсэн ой модонд устгаж үгүй болох аюул нүүрлээд байна. Хэрэв одоогийн үндэс сууриараа алдаатай бодлого үргэлжилсээр байвал нутгийн уугуул иргэдийн эрх зөрчигдөж, үлэмж үнэ цэнтэй ой мод устаж үгүй болно. Байгаль хамгаалах үйл ажиллагааг амжилттай явуулахын тулд тус улсын Засгийн газар нутгийн уугуул иргэд болон орон нутгийн иргэдийг ямар нэг гадуурхалтгүйгээр хүлээн авч, гол хамтрагчаа болгох ёстой. Эрх баригчид байгаль хамгаалах үйл ажиллагаанд дур зоргоороо тавьсан хоригоо цуцалж, байгаль хамгаалах, хууль сахиулах байгууллагын албан тушаалтнуудын дундах авлига болон хууль бус мод бэлтгэлийг таслан зогсооход шаардлагатай арга хэмжээ авах ёстой.

Энэхүү тайлан нь Камбож дахь хууль бус мод бэлтгэл, хүний эрх, ялангуяа нутгийн уугуул иргэдийн эрхийг хэрхэн зөрчиж байгаа үр дагаврын талаар Эмнести Интернэшнл байгууллагын хийж буй судалгааны нэг хэсэг юм.

БИДНИЙ УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫГ УСТГАЖ БАЙНА
КАМБОЖ: ДАРХАН ЦААЗАТ ОЙ ДАХЬ ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ,
ДАРАНГУЙЛАЛ, УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ
Эмнести Интернэшнл

АРГА ЗҮЙ

Энэхүү тайланг Эмнести Интернэшнлийн 2021 оны 6 – 10 дугаар саруудад хийсэн судалгаанд үндэслэн бичив. Судалгааны мэдээллийг Камбожийн Прэй Ланг, Прэй Прэйяа Рокагийн ойн сан болон эдгээр газрын ойролцоо ой хамгаалах үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн 20 гаруй идэвхтэнтэй хийсэн ярилцлага зэрэг олон эх сурвалжаас авсан юм.

Байгаль орчин хариуцсан албан тушаалтнуудаас орон нутгийн идэвхтнүүд, ойн санд үзүүлж буй хязгаарлалтууд нэмэгдэж байгаа талаар Эмнести Интернэшнлд мэдээлэл ирсэн учраас Прэй Ланг, Прэй Прэйяа Рокагийн ойн сан газрыг гүнзгийрүүлж судлахаар сонгосон билээ. Эмнести Интернэшнл өмнө нь Прэй Ланг дахь хязгаарлалтыг баримтжуулж байсан ба уг газрын нөхцөл байдлын талаарх тайлангууд гарсны дараа Прэй Прэйяа Рокатай холбоотой ижил төстэй мэдээлэл хүлээн авсан.

Аюулгүй байдлын шаардлагаар, Эмнести Интернэшнлээс ярилцлага авсан бүх идэвхтнүүдэд зохиомол нэр ашигласан ба газар, байршилтай холбоотой мэдээлэл зэрэг зарим мэдээллүүдийг орхисон. Ковид-19 цар тахлын улмаас зорчих хөдөлгөөн хязгаарлагдсан учраас бүх ярилцлагыг зайнаас хийлээ. Ярилцлагыг Кхмер хэлээр авсан. Орон нутгийн идэвхтэнүүд, хэвлэлийн мэдээ, сэтгүүлчид болон бусад эх сурвалжуудаас ярилцлагын үнэн бодит байдлыг боломжтой нөхцөлд баталгаажуулж ажилласан байна. Ярилцлагад орсон бүх хүнээс өмнө нь зөвшөөрөл авсан. Үүний өмнө, Эмнести Интернэшнлийн судлаач уг судалгааны зорилго, судалгааны мэдээллийг хэрхэн ашиглах, ярилцагчид учирч болзошгүй эрсдэлүүд зэргийг тайлбарлаад, зөвшөөрөл авсны дараа ярилцлагаа хийдэг.

Түүнчлэн, Эмнести Интернэшнлийн зүгээс олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээ, иргэний нийгмийн байгууллагуудын тайлан, үндэсний болон олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудын мэдээлэл, эрдэм шинжилгээний сэтгүүлүүд зэрэг нээлттэй эх сурвалжууд дахь мэдээллүүдийг ашиглан өргөн хүрээтэй судалгааны ажил явуулсан юм. Судлаачид мөн Камбож дахь уугуул иргэдийн эрх, хууль бус мод бэлтгэлтэй холбоотой үндэсний хууль тогтоомж, бодлого, олон улсын эрх зүйн орчныг судалсан.

Эмнести Интернэшнл 2021 онд тусгай хамгаалалттай хоёр газрын ойн устгалыг тооцоолохын тулд зайнаас тандан судлах сүүлийн үеийн мэдээлэл дээр дүн шинжилгээ хийлгэхээр Спэйс4Гүүд байгууллагатай гэрээ байгуулж ажилласан. Спэйс4Гүүд бол нийтийн нийгэм, хүрээлэн буй орчны нөлөө бүхий дэлхийн удирдагчдад газрын ажиглалт, хяналт, тайлагналт, шийдлийг санал болгодог газарзүйн мэдээллийн олон нийтийн байгууллага юм.

Камбожийн тусгай хамгаалалттай хоёр газарт нэвтэрч, газар дээр нь шалгах боломжгүй байсан тул тус байгууллага ойн устгал явагдаж буй шинэ газрыг илрүүлэхийн тулд *Сэнтинэл -1* радарын зураг болон *Планет Лабс* сар бүрийн өндөр нягтаршилтай хараа зүйн зургийн мозайк гэсэн хоёр үндсэн мэдээллийн баазыг ашигласан¹. Ой устгалын талаар өөр өөр үзүүлэлт ашигладаг хараат бус мэдээллийн эх сурвалж бүрд дүн шинжилгээ хийж, үзүүлэлтүүд огтлолцвол тухайн бүсэд ой устсан байх өндөр магадлалтай гэж үзсэн. Спэйс4Гүүд байгууллагын боловсруулсан алгоритмыг Синтетик диаграммын радар (SAR) Сэнтинэл -1-ийн 20 метрийн орон зайн нарийвчлалтай өгөгдөлд 2021 он хүртэл ургамалжилт байсан болон байгаа эсэхийг тодруулах зорилгоор ашигласан.

Синтетик аппаратур радар (SAR) буюу Сэнтинэл-1-ийн 20 метрийн орон зайн нарийвчлалтай өгөгдөлд 2021 он хүртэл ургамалжилт байсан болон байгаа эсэхийг тодруулах зорилгоор Спэйс4Гүүд байгууллагын боловсруулсан алгоритмыг ашигласан.

¹ Зайнаас тандан судлах арга зүйн бүрэн тодорхойлолтыг Спэйс4Гүүд, Камбож дахь ойн устгал, 2022 оны 1 сарын 24, ЭИ-ийн хамтарсан баримт бичгийн хуулбараас харна уу.

Мөн энэ хугацаанд, 4.77 метрийн орон зайн нарийвчлалтай Гарагийн Гадаргуу Тусгалын зурагт Ургамалжилтын Хэвийн байдлын Ялгааг тодорхойлох индекс (NDVI)-ийн тооцооллыг сар бүр хийж байсан. Устсан ой бүхий газруудын шинэ илрүүлэлтийг сар бүр тэмдэглэж алдаатай үр дүн гаргахгүйн тулд өмнөх 2 сарын зурагтай харьцуулсан. Тайлангийн товлолт хугацаанаас шалтгаалж 12 дугаар сарын зургийг харьцуулж, тооцоолоогүй. Үүссэн өгөгдлийн багцыг нэгтгэж, 2021 он хүртэлх ойн устгалыг тооцоолохын тулд огтлолцож буй газруудыг ашигласан.

Сэнтинэл-1 болон Планет Лабс зургуудад давхцаж буй мэдээлэлд тулгуурлан ой устгасан нь үнэн бодитой эсэхийг баталгаажуулсан. Гэвч Сэнтинэл-1 (SAR) өгөгдлийн орон зайн нарийвчлал нь 20 метр учир үр дүн нь хангалтгүй байх магадлалтай. Өөрөөр хэлбэл модыг сорчлон огтолж байгааг харуулсан маш өндөр нарийвчлалтай зургийг 20 метрийн нарийвчлалтай Сэнтинел-1 өгөгдөлд ашигласан алгоритм илрүүлж чадахгүй юм. Зайнаас тандан судлах илүү нягтралтай өгөгдөл эсвэл газрын нарийвчилсан судалгаагаар ойн устгалын талаарх мэдээллийг илүү өндөр магадлалаар илрүүлэх боломжтой.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 КАМБОЖИЙН УУГУУЛ КУЙ ИРГЭД

Камбожид ойролцоогоор 24 өөр бүлгийн уугуул иргэд амьдардагас Куй хүмүүс томоохон бүлгийн нэг юм. Куй иргэд Тайландын хойд, Лаосын өмнөд, болон Камбожийн хойд хэсэгт амьдардаг.² Камбож улс хүн амын тооллогодоо нутгийн уугуул иргэдийн мэдээллийг салгаж оруулдаггүй учир Куй иргэдийн тоог 14,200 – 125,000 гаруй гэж үздэг.³ Куй иргэд эрт үеэс тус улсын алслагдмал, ой модтой бүс нутагт амьдарч иржээ. Мөн Прэяа Вихеар, Стунг Трэнг, Крати болон Кампонг Том зэрэг хойд бүсийн хэд хэдэн мужуудад амьдардаг.

Эрдэм шинжилгээний судалгаанаас үзэхэд, Куй иргэд түүхийн янз бүрийн үед ялгаварлан гадуурхалт болон Кхмерийн соёлд хүчээр уусгах бодлоготой тулгарч иржээ. Судлаач Свифт 1975-1979 оны Ардчилсан Кампучийн талаар:

Улаан Кхмерүүд Куй хүмүүсийг Куй хэлээр ярьсных нь төлөө шийтгэдэг, яриаг нь ойлгохгүй учраас тэд хориглодог байсан” гэж онцолсон байдаг. 1979 онд Пол Потын дэглэм устсаны дараа Улаан Кхмерүүд Куй иргэдийн амьдардаг олон бүс нутагт байсаар байв.⁴

Улаан Кхмерүүдийн эрин өнгөрсний дараа Кхмерчүүдийн дотоод дахь шилжилт хөдөлгөөн, хөдөө орон нутгийн дэд бүтцийн хөгжил зэрэг нь Куй иргэдийн уламжлалт амьдралын хэв маягт шинэ сорилтуудыг авчирчээ:

1990-ээд оны эхээр Улаан Кхмерүүдийн төгсгөл ирж, дэд бүтэц хөгжихийн хэрээр Куй иргэдийн нутагт очих боломж хаа сайгүй нээгдсэн. 1998 онд буюу хэдэн арваны дараа, анх удаагаа Прэяа Вихеар мужид Камбожийн бусад нутгаас замаар очих боломжтой болжээ. 1990-ээд оны үед мод бэлтгэлийн компаниудад Куй иргэдийн нутгийн олон хэсэгт концесс олгож, дараа нь уурхайн концесс болон тариалалт хийгдэж эхэлсэн байна.⁵

Ихэнх Кхмер иргэдийн адилаар Куй хүмүүс голдуу Буддист, эсвэл Анимист шүтлэгтэй бөгөөд эдгээр шашнууд хоорондоо холилдсон байдаг. Куй хүмүүс “Кхмер хэлнээс эрс ялгаатай, өөрсдийн төрөл бүрийн хэлээрээ тод ялгардаг” бөгөөд хурим, ёслолын үйл ажиллагаа зэрэг соёлын өвөрмөц зан үйлээрээ ялгардаг. Ерөнхийдөө Кхмерүүдээс илүүтэйгээр Куй хүмүүсийн тосгоны амьдралд шүтлэг их үүрэг гүйцэтгэсэн.⁶ Куй иргэдийн соёл, итгэл үнэмшилд ой, уул болон ойролцоох тосгодоод амьдардаг орон нутгийн савдагууд ихээхэн ач холбогдолтой. Тэдгээр савдагууд Ахриак болон Ниак Та зэрэг янз бүрийн нэртэй байдаг.⁷ Куй иргэдийн соёл, итгэл үнэмшлээр бол, өвөг дээдсийн шүтэж ирсэн савдагтай уулс, ой мод, газрыг сүйтгэх нь тэдний соёл, оюун санааны сайн сайхан байдлыг дордуулж, амьжиргаагаа залгуулах чадварыг бууруулдаг байна.

MN
СУДАЛГААНЫ САН

² Тус улс дахь нутгийн уугуул иргэдийн бүлгийн талаарх тоон мэдээлэл нь эх сурвалжаасаа хамаараад өөр байдаг, албан ёсны тоо байхгүй. Цөөнхийн Эрхийн Олон улсын бүлэг, “Цөөнх болон нутгийн уугуул иргэдийн талаарх Дэлхий нийтийн лавлах – Камбож: Нутгийн уугуул иргэд”. <https://minorityrights.org/country/cambodia/>; Cambodia Indigenous Peoples' Alliance (CIPA), “The Indigenous World 2021: Cambodia”, 18 March 2021, iwgia.org/en/cambodia/4206-iw-2021-cambodia.html

³ Петер Свифт, Камбож дахь Куй хүмүүсийн угсаатны ялгаралд гарч буй өөрчлөлт: Уугуул иргэдийн онцлогийг уусгаж, дахин баталгаажуулж, бий болгож байгаа нь. 2013 оны 12 сар (hereinafter Swift, Changing ethnic identities), p. 296; Prey Lang Community Network, “Prey Lang”, 2015, preylang.net/about/the-forest

⁴ Петер Свифт, Камбож дахь Куй хүмүүсийн угсаатны ялгаралд гарч буй өөрчлөлт. 2013 оны 12 сар, 298-р хуудас.

⁵ Петер Свифт, Камбож дахь Куй хүмүүсийн угсаатны ялгаралд гарч буй өөрчлөлт. 2013 оны 12 сар, 299-р хуудас.

⁶ Петер Свифт, Камбож дахь Куй хүмүүсийн угсаатны ялгаралд гарч буй өөрчлөлт. 2013 оны 12 сар, 299-р хуудас.

⁷ Соёлын оршин тогтнол, улирал тутмын сэтгүүл. “Ойн сүнснүүд: Камбож дахь Куй хүмүүсийн сүнсэнд түшиглэсэн байгаль хамгаалал”, 2012 оны 6 сар, culturalsurvival.org/publications/cultural-survival-quarterly/spirits-forest-cambodias-kuy-people-practice-spirit-based

1.2 КАМБОЖ ДАХЬ НУТГИЙН УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙН АСУУДАЛ

Нутгийн уугуул иргэдийн эрхийг тус улсын дотоодын хууль тогтоомжоор зохистой хэмжээнд хамгаалаагүй байна.⁸ Гэхдээ үндэсний хэд хэдэн хууль, бодлогод уугуул иргэдийн талаар дурдсан байдаг ба “уугуул иргэдийн бүлэг”, “үндэстний цөөнх” болон “өндөрлөг газрын хүмүүс” гэх мэт өөр өөр нэр томъёо ашигласан байдаг.⁹

НҮБ-ын Нутгийн Уугуул Иргэдийн Эрхийн тухай Тунхаглал (НУИЭТ)-д нийтлэг зарчим буюу өөрийгөө тодорхойлох эрхийн хүрээнд уугуул иргэдийн эрхийг хэд хэдэн хэсэгт, тухайлбал, эрх тэгш байх, ялгаварлан гадуурхагдахгүй байх эрх, соёлын бүрэн бүтэн байдал, газар, нутаг дэвсгэр, байгалийн нөөцийн эрх, өөртөө засаглах, бие даасан байх эрх, мөн Чөлөөтэй, Урьдчилсан, Мэдээллээр хангасны үндсэн дээр Зөвшөөрөл авах (ЧУМЗ) эрх, болон бусад эрхүүдийг баталгаажуулсан байдаг. Камбож улс 2007 онд НУИЭТ-ыг батлахаар санал хурааж, уг тунхаглалд үндэслэгдсэн хүний эрхийн суурь гэрээнүүд, үүний дотор Арьс Өнгөөр Ялгаварлан Гадуурхах Үзлийн Бүх Хэлбэрийг Устгах тухай Конвенцид нэгдэн орсон. Гэхдээ тус улс ОУХБ (Олон Улсын хөдөлмөрийн байгууллага)-ын Нутгийн уугуул, Овгийн Хүмүүсийн тухай 169-р конвенцид нэгдэж ороогүй байна.¹⁰

НУИЭТ-ын хэд хэдэн зүйлд тусгагдсан ЧУМЗ авах эрх нь өөрийгөө тодорхойлох эрхээс үүдэлтэй юм¹¹. ЧУМЗ бол “Нутгийн уугуул иргэд болон тэдний бүлэг өөрсдөд нь нөлөө үзүүлж буй асуудлаар хамтын, бие даасан шийдвэр гаргах боломж бүхий механизм” юм.¹²

“Чөлөөт” гэдэг нь асуудал хэлэлцэх явцад “ямар нэгэн албадлага, айлган сүрдүүлэлт, заль мэх байхгүй байх” тухай ойлголт юм. “Урьдчилсан” гэдэг нь “ямар нэгэн үйл ажиллагаа эхлэхээсээ хангалттай өмнө нь зөвшөөрөгдсөн байх ёстой тухай ойлголт ба уугуул иргэдийн хоорондоо зөвлөлдөх, зөвшилцөхөд зарцуулагдах хугацаанд хүндэтгэлтэй хандах”-г ойлгоно. Эцэст нь, “Мэдээлэлтэй” гэдэг нь зөвлөлдөж буй асуудлын талаар үнэн зөв, бүрэн мэдээлэл авах боломжтой байх тухай ойлголт юм.¹³

НУИЭТ-д тусгагдсан бусад эрхүүд нь Куй иргэдийн өнөөгийн нөхцөл байдал, тэдний Прэй Ланг, Прэй Прэя Рокагийн ойд нэвтрэх, ойг ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд нь ихээхэн хамааралтай юм. Тухайлбал, 25-р зүйлд “Уугуул иргэд уламжлалт байдлаар эзэмшиж, ашиглаж ирсэн газар, нутаг дэвсгэр, ус, далай тэнгисийн эрэг болон бусад нөөц баялагтайгаа ёс заншилын сүсэг бишрэл өвөрмөц харилцаагаа хэвээр хадгалах, бэхжүүлэх, мөн эдгээр асуудлаар ирээдүй хойчийнхоо өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх эрхтэй” гэж заасан байдаг. 26.3-р зүйлд “Улс орнууд эдгээр газар, нутаг дэвсгэр, нөөц баялгийг хуулиар хүлээн зөвшөөрч, хамгаална. Ийнхүү хүлээн зөвшөөрөхдөө тухайн уугуул иргэдийн ёс заншил, уламжлал болон газар эзэмших тогтолцоог зохих ёсоор хүндэтгэн үзнэ” гэсэн шаардлага бий.

1.3 ПРЭЙ ЛАНГ, ПРЭЙ ПРЭЙЯ РОКА

Прэй Ланг бол Камбожийн хойд хэсгийн дөрвөн мужийг хамарсан, Зүүн Өмнөд Азийн эх газрын хамгийн нам дор газрын мөнх ногоон ой юм. Крати, Стунг Трэнг, Прэя Рока болон Кампонг Том мужуудын Куй, Кхмер, Лаосчууд энэ газраас урт удаан хугацааны турш хамааралтай амьдарч ирсэн юм. Энэхүү газар нь олон жилийн турш ой мод түшиглэн амьжиргаагаа залгуулж ирсэн түүхтэй Куйчуудын хувьд ихээхэн ач холбогдолтойн дээр тэдний хэлээр Прэй Ланг гэдэг

⁸ Камбожийн Нутгийн Уугуул Иргэдийн Холбоо, Камбож дахь уугуул иргэдийн нөхцөл байдал, 2019 оны 1 сар, upr-info.org/sites/default/files/document/cambodia/session_32_january_2019/js1_upr32_khm_e_main.pdf

⁹ Камбожийн Нутгийн Уугуул Иргэдийн Холбоо, Камбож дахь уугуул иргэдийн нөхцөл байдал. (өмнө иш татсан)

¹⁰ НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар. tbinternet.ohchr.org/_layouts/15/TreatyBodyExternal/Treaty.aspx?CountryID=29&Lang=EN

¹¹ Нутгийн уугуул иргэдийн эрхийн шинжээчдийн тогтолцоо. “Уугуул иргэдийн эрх болон шийдвэр гаргалтанд оролцох эрхийн талаарх сүүлийн судалгаа”. A/HRC/EMRIP/2011/2, 26 May 2011, para. 18, <https://www.ohchr.org/Documents/Issues/IPeoples/EMRIP/AEVfinalreportStudyIPRightParticipate.pdf>

¹² Азийн Уугуул Иргэдийн Пакт, “Нутгийн уугуул иргэдэд зориулсан ЧУМЗ-ийн сургалт”, 2014 он, 10-р хуудас.

¹³ НҮБ-ын ХЭДКГ, “Нутгийн уугуул иргэдэд зориулсан ЧУМЗ-ийн сургалт”, 2014 он, 10-р хуудас.

нь “манай ой” гэсэн утгатай юм. Прэй Ланг нь Куй хүмүүсийн ялгарал, соёл, оюун санааны амьдралын чухал хэсэг болохоос гадна тэдний амьжиргааны гол эх сурвалж болсоор иржээ¹⁴.

Прэй Ланг бол дэлхийн биологийн төрөл зүйлийн 10 халуун нэг бөгөөд манай гаригийн “биологийн төрөл зүйлийн хувьд хамгийн баялаг, аюулд өртөөд буй” бүс нутаг юм. Олон зүйлийн ховор амьтан, тухайлбал, залаат гиббон, Азийн одос үхэр болон Азийн заан зэрэг нэн ховор, устах аюул нүүрлээд буй амьтдын өлгий нутаг юм.¹⁵

Прэй Лангийн ойн дийлэнх хэсгийг 2016 онд (ойролцоогоор 600 мянган га талбайн 431,683 га) Зэрлэг амьтан ургамлын дархан цаазат газар хэмээн албан ёсоор тодорхойлсон. Дархан цаазат газар нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 7-р зүйлд зааснаар хамгаалагдах ёстой ба тус газрын дотор мод бэлтгэх үйл ажиллагаа явуулах хориотой. Прэй Лангийн бусад хэсгүүдийг Эдийн засгийн газрын концессийн (ЭЗГК) бодлогын дагуу хөдөө аж ахуйн бизнес эрхэлдэг компаниудад түрээслүүлсэн байна.

Тус газрыг дархан цаазтай болгосон хэдий ч хууль бус мод бэлтгэл хяналтаас гарсан учраас Прэй Ланг ноцтой аюулд өртөөд байна. Прэй Лангийн Орон Нутгийн Иргэдийн Сүлжээ (ПЛОНИС)-ний мэдээлснээр, 2001-2008 онд 41,758 га ой мод устгасан нь Прэй Лангийн дархан цаазат газрын бараг 10 хувьтай тэнцэх юм. Мэрилэндийн Их Сургууль, Дэлхийн Ойн Хяналт байгууллагатай хамтран гаргасан тоон мэдээллээс харахад 2020 онд 9000 гаруй га ой устсан ба онд өмнөх онтой харьцуулахад 20 хувиар илүү ой мод устжээ.

ПЛОНИС нь 2000-аад оны эхэн үеэс Прэй Лангийн ойг хамгаалахаар ажиллаж буй орон нутгийн иргэдийн олонд танигдсан бүлэг юм. Тэд “уул уурхай, хөдөө аж ахуйн бизнес, хууль бус мод бэлтгэлээс өвөг дээдсийнхээ газар нутгийг хамгаалах, их хэмжээгээр булаан авахаас сэргийлэх”, “ойг хамгаалах, мөн ойн дагалт баялгаар амьжиргаагаа залгуулж буй 200 мянга орчим хүний амьжиргааг хамгаалах”-аар ажилладаг.¹⁶ ПЛОНИС Прэй Ланг даяар ойн эргүүл хийж, мод бэлтгэлийг таслан зогсоож, гинжит хөрөөг хураан авч, уг бүс нутаг дахь хууль бус мод бэлтгэл, хулгайн ангийн талаар дэлгэрэнгүй тайлан бэлтгэж гаргадаг.¹⁷

Прэй Прэйя Рока бол Прэйя Вихеар мужид байдаг ой юм. Прэй Прэйя Рока нь Куй иргэдийн олон үеийн туршид ан агнах, ойн дагалт баялаг цуглуулах чухал ач холбогдолтой газар байсаар иржээ. Домог яриагаар бол, Куй хүмүүс энэ нутагт өнө эртнээс суурьшсан¹⁸ бөгөөд тэд Ангорын үед төмөр хайлуулах ажилд оролцож байсан байх магадлалтай.¹⁹ Багаар бодоход хэд хэдэн үеийн туршид одоогийн Прэй Прэйя Рокагийн бүс нутаг нь (мөн баруун тийш Кулэн Бром Тэпийн Тусгай хамгаалалттай газар, зүүн тийш Чаэпийн Дархан цаазат газар) ан агнуур болон ахуйн зориулалттай мод бэлтгэл (байшин барих болон гэр ахуйн зориулалтаар), ойн дагалт баялаг бэлтгэх гол газар байсаар ирсэн.

2016 онд Прэй Прэйя Рокагийн нэг хэсэг буюу 90 мянган га ойг Байгаль орчны яамны хамгаалалтад дархан цаазат газар болгохоор шийдвэрлэжээ. Прэйя Прэйя Рокагийн Ойн Нутгийн Иргэдийн Сүлжээ (ППРОНИС) нь ойролцоогоор 1997 оноос хойш ойн эргэн тойронд идэвхтэй эргүүл хийж, өөрсдийн хүчин чармайлтыг сурталчлах зорилгоор ойн бүсэд баяр ёслол хийсээр ирсэн тосгоны иргэдийн чөлөөт сүлжээ юм. 2016 онд тус бүс нутгийг дархан цаазат газар болгосноос хойш тус сүлжээнийхэн байгаль орчны яамтай нааштай харилцаатай болж эхэлж байсан ч 2019 оноос эхлэн хууль бус мод бэлтгэлийн хэмжээ эрс нэмэгдэж, тэдний ой хамгаалах бие даасан үйл ажиллагааг яамнаас хориглосноос хойш энэхүү харилцаа муудаж эхэлжээ.

СИ.МН
СУДАЛГААНЫ САН

¹⁴ Прэй Ланг Нутгийн Иргэдийн Сүлжээ, “Прэй Ланг”, 2015, preylang.net/about/the-forest

¹⁵ ПРЭЙ ЛАНГИЙН БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ. Крати, Кампонг Том, Стунг Трэнг болон Вихеар мужууд.

¹⁶ Прэй Ланг Нутгийн Иргэдийн Сүлжээ, 9-р Хяналт үнэлгээний тайлан: Прэй Лангийн ойн нөхцөл байдал.

¹⁷ Прэй Ланг Нутгийн Иргэдийн Сүлжээ, 9-р Хяналт үнэлгээний тайлан: Прэй Лангийн ойн нөхцөл байдал. ПЛОНИС нь ой хамгаалах талаар гаргасан хүчин чармайлтынхаа төлөө олон улсын олон шагнал хүртэж байжээ. Хамгийн сүүлд, Дэлхийн Байгаль хамгаалах 2020 Форумаас өөрсдөд нь ихээхэн эрсдэлтэй нөхцөл байдалд ч биологийн олон янз байдлыг хамгаалахын төлөө тэмцсэн хүмүүсийг шагнадаг Байгаль хамгааллын баатрууд шагналыг хүртсэн.

¹⁸ Бро Ме бүлэгт 2020 оны 11 сард Куй иргэдийн дунд хийсэн судалгаанд үндэслэв.

¹⁹ Митч Хэндриксон болон бусад, “Төмөртэй уулын сүүдэрт хүдэр хайлах нь: Камбожийн Пном Дек хавийн аж үйлдвэрийн бүс нутагт хийсэн урьдчилсан хээрийн шинжилгээний ажил (Манай Эриний 9-20-р зуун)”, *Asian Perspectives* (2017), хуудас. 55-91

БИДНИЙ УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫГ УСТГАЖ БАЙНА

**КАМБОЖ: ДАРХАН ЦААЗАТ ОЙ ДАХЬ ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ,
ДАРАНГҮЙЛАЛ, УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ**

Эмнести Интернэшнл

1.4 КАМБОЖ ДАХЬ ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ

Сүүлийн хэдэн арван жилд дэлхийн хэмжээнд ой мод нь хамгийн хурдан устаж байгаа улсуудын тоонд Камбож байнга багтах болов. Дэлхийн Ойн Хяналт байгууллагын мэдээлснээр, тус улс 2001-2020 оны хооронд бараг 2.5 сая га ойн бүрхэвчээ алдсан байна.²⁰ Энэхүү устгалын бараг тал хувь нь үндсэн буюу нас гүйцсэн, нүүрстөрөгчийн хуримтлалд чухал үүрэг гүйцэтгэдэг, мөн устах аюулд ороод байгаа биологийн олон төрөл зүйлийн амьдрах орчин болдог байгалийн анхдагч ойд тохиолдсон байна.²¹

Модны экспорт нь 1975-1979 онуудад тус улсын төрийн эрхийг барьж байсан Камбожийн Коммунист Намын (ККН эсвэл Улаан Кхмер) санхүүжилтийн гол эх үүсвэр байв. Тус улсад хэдэн арван жил үргэлжилсэн цуст мөргөлдөөнийг зогсоосон Парисын Энхийн Хэлэлцээрийн дараагаас буюу 1990 оны дунд үеэс 2000 оны хооронд хууль бусаар мод бэлтгэх явдал маш ихээр нэмэгдсэн. Камбож улсын дайнаас энх тайван руу, нэг намт төрөөс ардчилал руу, социалист эдийн засгаас чөлөөт зах зээл рүү шилжих гэсэн гурван шилжилтийн үе хөгжлийн сангуудын их хэмжээний туслалцаа, олон улсын анхаарал зэрэгтэй давхцсан нь тус улсыг олон талаар, их хэмжээгээр өөрчилсөн юм. Дээрх хугацаанд олон Камбож иргэн үгээгүй ядуурлаас ангижирсан боловч газар хувьчлал болон ЭЗГК олгох үйл ажиллагаа зэрэг нь өргөн хүрээний байгаль орчны доройтол, газаргүй болох, албадан нүүлгэлт зэрэг олон асуудлыг үүсгэсэн байна.

ЭЗГК бол их хэмжээний газрыг эдийн засгийн зорилгоор хөдөө аж ахуй, уул уурхай, усан цахилгаан станц гэх мэт төслүүдийг хэрэгжүүлэхийн тулд хувийн компаниудад урт хугацаагаар олгож буй түрээс юм. Олон тооны ЭЗГК-ийг ойн сан бүхий газарт олгосноор Камбожийн Нутгийн уугуул иргэдэд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж, албадан нүүлгэлт болон хүний эрхийн бусад зөрчлүүдийг үүсгэсэн байна. Эмнести Интернэшнл 2010 оноос хойш Прэй Лангийн бүс нутагт олгосон ЭЗГК-оос үүдэлтэй хүний эрхийн сөрөг нөлөөллүүдийг баримтжуулсаар байгаа билээ²².

Камбожийн хүний эрхийн байгууллагын (LICADHO) мэдээлснээр бол, Камбожийн Хаант Засгийн газар 2 сая гаруй га газрыг хамарсан, 301 ЭЗГК олгосон байна.²³ “Эдгээр Концессийн багадаа 98 нь уугуул иргэдийн газар, нутаг дэвсгэр, нөөц баялгийг хамарч байгаа” Камбож дахь Нутгийн уугуул иргэдийн эрхийн бүлгүүд баримтжуулсан ба “уугуул иргэдэд хамааралтай эдгээр хөгжлийн санаачилгуудын аль нь ч ЧУМЗ авах үе шатыг хэрэгжүүлээгүй байна”.²⁴ Мөн ЭЗГК-ийг уугуул иргэдийн нутаг дээр болон тэдний зэргэлдээх нутагт хэрэгжүүлсэн нь “уугуул иргэдийн соёл, зан заншил, амьжиргаа, боловсрол, эрүүл мэнд, хөгжил, сайн сайхан байдалд нөхөж баршгүй хохирол учирч байгааг” онцолжээ.²⁵

Камбожийн эрх бүхий албан тушаалтнууд ойн устгалд хөдөөгийн ядуу иргэд буруутай, тус улсад хууль бусаар их хэмжээний мод бэлтгэгдэхгүй байгаа гэж нотлохыг үргэлж хичээдэг.²⁶ Гэхдээ Камбож дахь хууль бус мод бэлтгэл, ойн устгалын талаар хийсэн судалгаанууд нь эрх баригч Камбожийн Ардын Нам болон Ерөнхий сайд Хун Сен нарын нягт холбогдсон бизнесийн ашиг сонирхол ой устахад том хүчин зүйл болдог гэдгийг байнга онцолдог.

Жишээ нь, Глобал Витнес байгууллагаас Прэй Лангийг оруулаад, Камбож дахь хууль бусаар бэлтгэсэн модны худалдааны талаар өргөн хүрээтэй шалгалт хийжээ. 2007 онд тус байгууллагаас “Камбожийн мод бэлтгэлийн хамгийн том бүлэглэлийг Ерөнхий сайд Хун Сений хамаатнууд болон бусад өндөр албан тушаалтнууд удирддаг” гэж дүгнэсэн байдаг. Энэхүү ашиг сонирхол нэгтэй модны наймааны бүлэглэлийн гишүүдийн үйл ажиллагаанд Прэй Лангийн ой дахь их

УУГУУЛ ИРГЭДИЙН
СУДАЛГААНЫ САН

²⁰ Дэлхийн Ойн Хяналт, “Ойн бүрхэвчээ алдаж буй нь – улс, мужийн нэр”. www.globalforestwatch.org 2022 оны 1 сарын 13-нд хандсан.

²¹ Кай Крэйсэк, “Камбожийн ойд юу тохиолдов?” блогийн нийтлэл, 2019 оны 9 сарын 26, <https://www.globalforestwatch.org/blog/data-and-research/whats-happening-in-cambodias-forests/> 2022 оны 1 сарын 26-нд хандсан. www.globalforestwatch.org

²² Эмнести Интернэшнл, “Камбож: Камбож дахь Нүүлгэн шилжүүлэлт ба Эсэргүүцэл: Таван эмэгтэй түүхээ ярьж байна”, 2011 оны 11 сарын 24. amnesty.org/en/documents/asa23/006/2011/en

²³ LICADHO, Газрын Концессийн Тоон мэдээлэл, licadho-cambodia.org/land_concessions (accessed on 12 2022 оны 1 сарын 12-нд хандсан).

²⁴ Камбожийн Нутгийн Уугуул Иргэдийн Холбоо, Камбож дахь уугуул иргэдийн нөхцөл байдал, 2019 оны 1 сар, upr-info.org/sites/default/files/document/cambodia/session_32_-_january_2019/js1_upr32_khm_e_main.pdf, 11-р догол мөр.

²⁵ Камбожийн Нутгийн Уугуул Иргэдийн Холбоо, Камбож дахь уугуул иргэдийн нөхцөл байдал, 2019 оны 1 сар, upr-info.org/sites/default/files/document/cambodia/session_32_-_january_2019/js1_upr32_khm_e_main.pdf, 12-р догол мөр.

²⁶ Ричард Финни, “Камбожийн Хун Сен ойн устгалд ядуусыг буруутгаж байна”, 2021 оны 11 сарын 11, Radio Free Asia, rfa.org/english/news/cambodia/blames-11112021080133.html

хэмжээний хууль бус мод бэлтгэл ч орно”.²⁷

Байгаль орчны Мөрдөн шалгах Агентлаг (БОМША) нэртэй бас нэг байгаль орчны ТББ тус улс дахь хууль бус модны худалдааны талаар мэдээлжээ. Тэдний судалгаагаар бол, Вьетнам улсын модны эрэлт нь Камбожийн ой устгаж буй гол хүчин зүйл болж байгаа бөгөөд хууль бусаар бэлтгэсэн их хэмжээний мод Вьетнам руу цааш нь экспортлохоор тээвэрлэгддэг байна. БОМША-ын зүгээс Камбож, Вьетнам улсууд хоорондоо хил нэвтрэхэд хялбар байдаг, мөн хоёр талын хилийн хууль сахиулах албан хаагчдын дунд түгээмэл тархсан авлига нь Камбожийн тусгай хамгаалалттай ойн модыг цөлмөхөд хүргэж байна гэж дүгнэжээ.²⁸

Вьетнам улс модон тавилгын дэлхийн томоохон экспортлогчдын нэг юм. Вьетнамын төрийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн 2021 оны 5 дугаар сард мэдээлснээр тус улс АНУ-д тавилга экспортлогчийн хувиар Хятадыг гүйцэж түрүүлэн, зөвхөн 2020 онд л гэхэд АНУ руу 7.4 тэрбум ам.долларын тавилга экспортолсон гэжээ. Вьетнамын модны экспорт тасралтгүй нэмэгдсэнээр хяналт шалгалт ч мөн нэмэгдсэн байна. АНУ-ын Худалдааны Төлөөлөгч (АНУХТ) 2020 оны 10 сард тус улсын хууль бусаар бэлтгэгдсэн мод ашиглалт болон импортын асуудлаар хяналт шалгалт эхлүүлж, үүний явцад “Камбожоос Вьетнам руу экспортолсон модны үлэмж хэсгийг дархан цаазат газар зэрэг тусгай хамгаалалттай газраас бэлтгэсэн болохыг тогтоосон...” гэсэн хэдий ч Камбож нь Вьетнамын модны импортын чухал эх үүсвэр хэвээр байна.²⁹

АНУХТ-ын хянан шалгах ажиллагаа 2021 оны 10 дугаар сард Вьетнамын Засгийн газар болон АНУХТ хоорондын хэлэлцээрээр дуусгавар болсон. АНУХТ-ын мэдэгдсэнээр Вьетнамын Засгийн газар “хууль бусаар бэлтгэсэн, худалдсан модыг зах зээлд нийлүүлэхгүй байх, хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийг хамгаалах, модны гарал үүсэл нь тодорхойгүй улс орнуудтай хил, гаалийн хяналт, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах талаар хамтран ажиллах үүрэг амлалт авсан” байна.³⁰ Энэхүү гэрээ Вьетнамд нийлүүлдэг Камбожийн хууль бус модны худалдаанд ямар нөлөө үзүүлэхийг харах л үлдлээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

²⁷ Глобал Витнес, Камбожийн гэр бүлийн мод, 2007 оны 5 сарын 31, globalwitness.org/en/reports/cambodias-family-trees. Мөн Глобал Витнес, Камбож дахь Үндэстэн дамнасан, Зохион байгуулалттай гэмт хэрэг, Ойн гэмт хэргийн эсрэг: Прэй Лангийн дархан цаазат газрыг тойрсон хууль бус үйл ажиллагаа, 2021 оны 3 сарын 26, globalinitiative.net/analysis/forest-crimes-cambodia

²⁸ БОМША, Цуврал гэмт хэрэг: Камбожийн хууль бусаар бэлтгэсэн модыг Вьетнам импортоор авсаар байна, 2018 оны 5 сарын 31, eia-international.org/wp-content/uploads/eia-serial-offender-web.pdf, БОХША, Давтан гэмт хэрэг: Вьетнам хууль бус модны наймааг тасралтгүй хийж байна, 2017 оны 5 сарын 8, eia-international.org/wp-content/uploads/Repeat-Offender.pdf

²⁹ АНУ-ын Худалдааны Төлөөлөгчийн Газар, 301-р хэсэг, Вьетнамын мод бэлтгэл, ustr.gov/issue-areas/enforcement/section-301-investigations/section-301-vietnam-timber

³⁰ АНУ-ын Худалдааны Төлөөлөгчийн Газар, АНУХТ-өөс АНУ болон Вьетнамын хооронд мод бэлтгэлийн 301-р хэсгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах гэрээ байгуулснаа мэдэгдлээ. 2021 оны 10 сарын 1, str.gov/about-us/policy-offices/press-office/press-releases/2021/october/ustr-announces-agreement-between-united-states-and-vietnam-resolve-timber-section-301-investigation

2. «ТЭНД БАРАГ ЮУ Ч ҮЛДСЭНГҮЙ»: КАМБОЖ ДАХЬ БАЙГАЛИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ КҮЙ ХҮМҮҮСИЙН СОЁЛ, ХҮНИЙ ЭРХЭД ЗАНАЛХИЙЛЖ БАЙНА

Энэ бүлэгт хууль бус мод бэлтгэл Куй иргэдийн соёлд үзүүлж буй аюул заналын талаар дэлгэрэнгүй тайлбарлаж, хууль бус мод бэлтгэлийн асуудлаар Куй хүмүүс нутгийн уугуул иргэд болохынхоо нь хувьд эдлэх эрхийг хамгаалах Камбожийн эрх баригчдын хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагад дүн шинжилгээ хийсэн болно.

Ой модыг ийнхүү хууль бусаар, хяналтгүйгээр огтолж байгаа нь тэдний соёлыг устгах вий хэмээн санаа зовж байгаагаа Эмнести Интернэшнлд ярилцлага өгсөн бүх Куй хүмүүс илэрхийлж байв. Камбожийн ой мод устаж байгаа нь уламжлалт амьжиргаа, зан үйл болон соёлоо хадгалж үлдэхийн тулд ойг түшиглэдэг Куй хүмүүсийн хувьд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна. Тэдний олон зан үйл ойтой биет байдлаар холбоотой байдаг. Тухайлбал, өвөг дээдсийн оршуулгын газар ойн гүнд, Нэак Та болон ойн бусад сүнснүүд ойн онцгой хэсэгт амьдардаг гэж итгэдэг байна.

Энэ бүлэгт үргэлжлүүлэн тайлбарласанчлан, Камбожийн байгаль орчны асуудал хариуцсан албан тушаалтнууд хууль бус мод бэлтгэлээс үүдэлтэй хүний эрхийн зөрчлөөс Куй иргэдийн эрхийг хамгаалах үүргээ биелүүлээгүйгээс гадна ихэнх нь уг авлигад идэгдсэн худалдаанд идэвхтэй оролцож байна.

2.1 КҮЙ ХҮМҮҮСИЙН СОЁЛ БОЛОН СҮСЭГ БИШРЭЛД ҮЗҮҮЛЖ БҮЙ НӨЛӨӨ

Прэй Ланг, Прэй Прэйяа Рока хавийн Куй иргэд ариун дагшин дөрвөн төрлийн ойн дүрсэлсэн нь:

БИДНИЙ УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫГ УСТГАЖ БАЙНА
КАМБОЖ: ДАРХАН ЦААЗАТ ОЙ ДАХЬ ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ,
ДАРАНГУЙЛАЛ, УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ
Эмнести Интернэшнл

1. Савдаг орших нутаг /өнгөрсөн үеийн сүнснүүд амьдардаг, эсвэл хуучин тосгод, аман ярианд тодорхой үйл явдал болсон гэж үздэг ач холбогдолтой газрууд/,
2. Неак Тагийн мөргөлийн газрууд /Неак Та амьдардаг гэж үздэг, хүмүүс аз хийморь гуйж, тахил өргөдөг газрууд/,
3. Оршуулгын газрууд /өвөг дээдсийн сүнсний хүч шингэсэн гэж үздэг оршуулгын газрууд/,
4. Түүхэн дурсгалт газрууд /хэдэн зуун жилийн өмнөх хуучин сүм хийд, дурсгалт газруудын тууриуд/

Ойн сан бүхий газар нь Куй иргэдийн сансар огторгуйн тухай үзлийн салшгүй нэг хэсэг учраас ойн хомсдол нь тэдний сүсэг бишрэлд итгэл үнэмшил, дадал зуршлаас нь хэрхэн холдуулж байгаа талаар тэд Эмнести Интернэшнлийнхэнд ярьсан байна. Ярилцлага өгсөн нэг хүн хууль бус мод бэлтгэл болон Прэй Прэйяа Рокагийн ойд нэвтрэхийг Засгийн газраас хязгаарласнаас үүдэлтэй тэдэнд учраад байгаа асар их хохирлын талаар тайлбарлахдаа:

Энэ бол үнэхээр эмгэнэл – Бидний уламжлал устаж, одоо ямар болоод байгааг мэдэхгүй, гэхдээ ихийг алдсан мэт санагдаж байна. Бидний соёл, уламжлал бараг бүхэлдээ үгүй болсон мэт санагдах боллоо. Голдуу өтгөн ой мод, тахилын газруудыг устгасан учраас маш их хэмжээний ариун дагшин ой мод устаж үгүй болсон.

2005 оноос өмнө ой мод их өтгөн шигүү байсан юм. Одоо энэ бүрхэвч нимгэрснээр ой маш их өөрчлөгдөж, гал гарах үед ойн ургамал юу ч үгүй шатах болсноор урьдын адил байхаа больсон. Энэ бүхэн өөрчлөгдөхийн хэрээр ариун дагшин байдлаа алдаж, улмаар хүмүүс эдгээр газруудад өргөл өргөхөөр ирэхээ, хүндэтгэхээ больж байна. Зарим газарт газар тариалан эрхлэхээр цэвэрлэгээ хийсэн хүмүүс ч байна.³¹

Өөр нэг хүн ариун ойгоос мод бэлтгэж байгаа нь Куй соёл, зан заншлыг хойч үеийнхэндээ үлдээх явдлыг үндсээр нь үгүй хийж байгааг тайлбарлахдаа:

Ой модыг устгаж, ашиглах боломжгүй болгож байгаа нь соёлыг маань устгаж байна. Бидний соёлоос юу ч үлдээгүй мэт санагдах боллоо. Залуу үе маань ой модон дахь бидний хувьд чухал ач холбогдолтой бүх газрууд, Неак Тагийн тухай түүхийг хэзээ ч олж мэдэж чадахааргүй боллоо. Ойн гүнд эртний тосгод байдаг, бид одоо ч өвөг дээдсийнхээ сүнсэнд хүндэтгэл үзүүлдэг. Одоо ийм газруудыг мод бэлтгэлээс болоод устгасан. Бүх том модыг тайрч, эд өлгийн зүйлсийг тоносон.³² Прэй Прэйяа Рокагийн ойд маш эртний сүм хийд, дурсгалт газрууд байдаг. Эдгээр газруудын тухай би тосгоныхоо ахмадуудаас сонсож байсан юм. Одоо эднийг устгасан учраас энэ соёл ч дагаад устах болно. Оюун санааны хүч шингэсэн, Неак Тад өргөл өргөдөг өөр газрууд бий гэж настайчууд ярьдаг³³ гэсэн юм.

Ариун дагшин ой нь сүнслэг ой болон Неак Тад өргөл өргөдөг газрууд гэсэн хоёр төрөлтэй бөгөөд Прэй Прэйяа Рокагийн ариун ой нь эхний төрөлд багтдаг. Бро Мегээс холгүй орших газар нь маш их хүндэтгэл хүлээсэн Неак Та буюу найман толгойтой Неак Тагийн газар юм. Энд Неак Тагийн бунхан байдаг ба хүмүүс зан үйл, ёслол хийсээр байгаа боловч ойр орчмын газар нь гурван талаараа хувийн өмч болсон бөгөөд нөгөө талд нь Прэй Прэйяа Рокагийн устан доройтож буй ой байдаг. Энэ нь тэдний соёл, уламжлалд маш их сөрөг нөлөө үзүүлж байгааг ярилцлага өгсөн хүмүүс онцолсон байна.³⁴

Нэгдүгээрт, уг газар нь хувийн өмчийн газраар хүрээлэгдсэн учир нэвтрэхэд бэрхшээлтэй, иймд хүмүүс байнга очиж чаддаггүй. Цаг хугацаа өнгөрөх тусам хүмүүс Неак Та-тай холбоотой уламжлал, харилцаагаа алдана гэж ярилцлагын оролцогчид үзэж байв. Хоёрдугаарт, уг газар

³¹ Эмнести Интернэшнлийн Хор Дутай хийсэн ярилцлага. 2021 оны 8 сар.

³² Эмнести Интернэшнлийн Чан Тудатай хийсэн ярилцлага. 2021 оны 9 сар.

³³ Эмнести Интернэшнлийн Чан Тудатай хийсэн ярилцлага. 2021 оны 9 сар.

³⁴ Эмнести Интернэшнлийн Чан Тудатай хийсэн ярилцлага. 2021 оны 9 сар.

БИДНИЙ УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫГ УСТГАЖ БАЙНА

КАМБОЖ: ДАРХАН ЦААЗАТ ОЙ ДАХЬ ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ,
ДАРАНГУЙЛАЛ, УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ

Эмнести Интернэшнл

доройтохын хэрээр Неак Тагийн хүч суларч, хүмүүсийн өргөл багасна. Энэ нь газар, ус, нутгийн иргэдийг хамгаалах Неак Тагийн чадвар багасна гэсэн үг юм. Гуравдугаарт, ойн устгал нь Неак Таг хилэгнүүлж, тэр хавийн үхэр, одос зэрэг амьтад, мөн хүмүүс өвчилж, үхэж байна гэдэгт итгэж байв.³⁵

Энэ бол ойн доройтолд өртсөн Прэй Прэяа Рока орчмын, Неак Тагийн оршдог олон ариун газруудын нэг юм. ОКок тосгоны ойролцоох Неак Тагийн өөр нэгэн чухал газар мөн ихээр доройтжээ.

Судалгаанд оролцогчид ирсэн Прэй Лангийн гурван дүүргийн хэмжээнд өмнө нь дурдсан дөрвөн төрлийн ариун дагшин ой (сүнстэй ой, Неак Тагийн бунхан, оршуулгын газрууд, сүм хийдийн балгас) бүгд доройтож, сүйрч байна. Прэй Вихеарын Прасат Гоол дахь Анкорын өмнөх үеийн сүм хийдийн туурь байсан нэг газрын модыг ихээр тайрснаас устах аюул нүүрлэжээ.³⁶

Прэй Вихеар, Кампонг Том хоёрын хил дээрх сүнстэй ойг мөн их хэмжээгээр огтолжээ. Прэй Вихеараас ирсэн Кенг Хуот хэлэхдээ:

Нуулгүй хэлэхэд, Прэй Ланг дахь бүх ариун дагшин газруудын модыг огтолсон. Мод бэлтгэгчдэд ариун газар огт хамаагүй, модтой газрыг л олж тайрдаг. Голын эрэг дагуу байрладаг, эсвэл эртний сүм хийдийн үлдэгдэл байдаг олон ариун дагшин газруудыг мод бэлтгэгчид огтхон ч анхаарч үзэлгүйгээр үнэ цэнтэй моднуудыг бүгдийг нь тайрсан байна. Үүний үр дагавар бол бидний уламжлал, итгэл үнэмшил буурч буй явдал юм. Ариун дагшин газруудад залбирах залбирал, өргөх өргөлийн хамт бидний итгэл үнэмшил, уламжлал уламжлагдаж ирсэн бөгөөд энэ уламжлал биднийг нэгтгэдэг.

Хэрвээ энэ газруудыг сүйтгэчихвэл, эсвэл бид тийшээ очиж чадахаа больчихвол хэн ч тийшээ явахаа болино. Бид өргөл өргөхөө больж, сүнс болон ариун газруудтай холбоо тасарч, өв уламжлал маань ч алдагдах болно. Үүнээс илүүтэйгээр, биднийг нэгтгэдэг байсан уламжлал үгүй болсноор бидний дундах эв нэгдэл алдагдана.³⁷

Крати дүүргээс ирсэн иргэн Тин Сот хууль бус, хяналтгүй мод бэлтгэлийн улмаас Куй соёлд аюул учраад байгаа талаар мөн л төстэй зүйл ярьжээ:

Манай ойн олон дагшин газар одоо хууль бус мод бэлтгэлээс болж сүйрээд байна. Бидэнд ой мод, тухайлсан том мод, хад чулуу зэрэгтэй холбоотой олон итгэл үнэмшил байдаг. Эдгээр газруудын олонх нь устсан, үүний улмаас олон тооны үхэр, одос болон бидний тэжээж байсан өөр олон амьтан өвчилсөн.

Мод бэлтгэл болон Байгаль орчны яамнаас тавьж буй хязгаарлалтууд манай уламжлал, соёлд хэт сөрөг нөлөө үзүүлж улмаар устгаж байна гэж хэлж болно. Бид цаашдаа тахил өргөх ойн ариун дагшин газар нутгийн иргэдтэй уулзах чухал газрууд руугаа хэрхэн явах болж байна аа.³⁸

Камбожийн эрх баригчид дотоодын болон олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийн дагуу нутгийн уугуул иргэдийн соёлын эрхийг гуравдагч этгээдийн аюул заналаас, тэр дундаа хууль бус мод бэлтгэлтэй холбогдсон томоохон компаниудаас хамгаалах үүргийг хуулиар хүлээсэн. Сүсэг бишрэлийн хувьд онцгой холбоотой уламжлал газар нутгийг үгүй хийж байгаа нь “Нутгийн уугуул иргэд уламжлалт байдлаар эзэмшиж, оршин амьдарч, ашиглаж ирсэн газар нутаг, ус, далайн эрэг болон бусад байгалийн нөөцтэйгөө сүсэг бишрэлийн өвөрмөц харилцаагаа хадгалах, бэхжүүлэх эрхтэй бөгөөд энэ талаар ирээдүй хойчийнхоо өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлэх үүрэгтэй” гэх НУИЭТ-ын 25-р зүйлд хамааралтай.

³⁵ Эмнести Интернэшнлийн Чан Самбат болон ЧанТудатай хийсэн ярилцлага. 2021 оны 9 сар.

³⁶ Эмнести Интернэшнлийн Чан Самбат болон ЧанТудатай хийсэн ярилцлага. 2021 оны 9 сар.

³⁷ Эмнести Интернэшнлийн Кенг Хуоттой хийсэн ярилцлага. 2021 оны 8 сар.

³⁸ Эмнести Интернэшнлийн Тин Соттой хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар.

НУИЭТ-ын 29.1 дэх хэсэгт:

“Нутгийн уугуул иргэд байгаль орчин болон өөрийн газар нутаг, нөөц баялгийнхаа хүчин чадлыг хадгалах, хамгаалах эрхтэй” гэж заасан. Түүнчлэн 31.1 дэх хэсэгт: “Нутгийн уугуул иргэд өөрийн соёлын өв, уламжлалт мэдлэг, уламжлалт соёлын илэрхийлэл, түүнчлэн хүний болон генетикийн нөөц, үр тариа, эм, амьтан, ургамлын аймгийн шинж чанарын тухай мэдлэг, аман уламжлал, уран зохиол, дизайн, спорт, уламжлалт тоглоом наадам, харах болон тайзны урлаг зэрэг шинжлэх ухаан, технологи, соёлоо хадгалах, хянах, хамгаалах, хөгжүүлэх эрхтэй” гэжээ.

Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн тухай Олон улсын Пактад тусгагдсан соёлын амьдралд оролцох эрхийг тайлбарлахдаа Эдийн засаг, Нийгэм, Соёлын Эрхийн Хорооноос:

“Нутгийн уугуул иргэдийн амьдралын хэв маяг өөрчлөгдөх, амьжиргааны түвшин нь доройтох, байгалийн нөөц, соёлын ялгаатай байдал нь алдагдахаас сэргийлэхийн тулд тэдний өвөг дээдсийн нутаг, байгальтай харьцах соёлын үнэт зүйл, эрхийг хүндэтгэж, хамгаалах ёстой” гэж тэмдэглэжээ. Тиймээс тунхаглалд оролцогч улсууд нутгийн уугуул иргэдийн нийтийн эзэмшлийн газар, нутаг дэвсгэр, нөөц баялгаа эзэмших, хөгжүүлэх, хянах, ашиглах эрхийг хүлээн зөвшөөрч, хамгаалах, хэрэв чөлөөтэй, урьдчилсан, мэдээллээр хангасны үндсэн дээр тэдний зөвшөөрлийг авалгүйгээр газар нутагт нь шилжин суурьшсан, ашигласан бол тухайн газар нутгийг уугуул иргэдэд буцаан өгөх арга хэмжээг авах ёстой³⁹ гэж тайлбарласан байдаг.

2008 оны Тусгай хамгаалалттай газрын тухай хуулийн дагуу 2016 онд Ерөнхий сайд Хун Сен дэд тогтоолд гарын үсэг зурж, Прэй Ланг, Прэй Прэяя Рокаг аль алиныг нь Зэрлэг амьтны дархан цаазтай газар гэж тодорхойлсон. Ойн хамгаалал, ашиглалт, орон нутгийн иргэдийн ойд нэвтрэх эрхийг зохицуулсан Байгаль хамгаалах, Байгалийн нөөцийн менежментийн тухай хууль /1996/, Газрын тухай хууль /2001/зэрэг дотоодын бусад хууль тогтоомжууд байна. Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай хуульд хамгаалалттай газарт мод огтлох, мод бэлтгэхийг хориглодог.

2002 оноос хойш улсын хэмжээнд арилжааны зорилгоор мод бэлтгэхийг хориглоод байгаа юм.⁴⁰

2.2 УЛАМЖЛАЛТ АХУЙ АМЬЖИРГААНД ҮЗҮҮЛЖ БҮЙ АЮУЛ

Куй иргэдийн амьжиргаа голдуу давирхайн олборлолт болон газар тариалангийн цэвэрлэгээ (ээлжийн буюу “газрыг хэсэгчилэн шатаах” тариалалт ч гэж нэрлэдэг)-нд тулгуурладаг. Тариалан эрхлэх зорилгоор ойн газрыг шатааж цэвэрлэн, хэдэн жил ашигласны дараа нөхөн сэргээхээр үлдээх нь тариалалтын нэг төрөл юм. Куй иргэд шинэ газрыг ийн цэвэрлэхийн өмнө сүнснүүдэд зориулан зан үйл хийдэг.⁴¹

Зэрлэг ойн мод нь Куй хүмүүсийн өдөр тутмын амьдралд нөлөөлсөөр ирсэн.

Онгон зэрлэг ойд ургадаг *диптерокарп* төрлийн модноос байгалийн гаралтай эфирийн тос олборлохын тулд цоолдог давирхайн цоргонууд нь Куй иргэдийн амьжиргаанд онцгой ач холбогдолтой байжээ. Модноос давирхайг нь гаргаж авахын тулд модны ёроолд ойролцоо нүх гаргаад, давирхайн урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор долоо хоног бүр богино хугацаагаар шатаадаг аж. Нэг модноос ийм байдлаар давирхай гаргаж авах нь хэдэн арван жилийн турш ашиглах боломж нөөцтэй гэдгийг судалгаагаар тогтоожээ.⁴² Ахуйн хэрэглээнд чанар муу ч

³⁹ НҮБ-ын ЭЗНСЭХ, “Хүн бүрийн соёлын амьдралд оролцох эрхийн талаарх 2009 оны 21-р ерөнхий санал зөвлөмж”. ЭЗНСЭОУП. UN Doc. E/C.12/GC/21, 2009 оны 12 сарын 11, догол мөр 36.

⁴⁰ ЭЗГК олгох хүрээнд 2001 оны Газрын тухай хуульд заасны дагуу хөдөө аж ахуйн газар тариалангийн зориулалтаар газар чөлөөлөх явдал л уг хоригт хамаарахгүй юм.

⁴¹ Свифт, Угсаатны бүлгүүдийн өвөрмөц байдал өөрчлөгдөж байгаа нь, 2013 оны 12 сар, хуудас 300.

⁴² Том Эванс болон бусад, “Камбожийн Өмнөд Мондулкири дэх давирхай олборлолт иргэдийн амьжиргаа ба ойн нөхөн сэргээлт, менежментэд үзүүлж буй нөлөөллийн талаарх судалгаа”, “Зэрлэг амьтан, ургамлыг хамгаалах нийгэмлэг”, 2003 оны 1-р сар. s3.amazonaws.com/WCSResources/file_20120709_214332_Evans-et-al-Resin-SBCA_JhYoQ.pdf (үүнээс хойш Эванс болон бусад, “Давирхай олборлолт болон амьжиргааны талаарх судалгаа” гэх).

БИДНИЙ УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫГ УСТГАЖ БАЙНА

КАМБОЖ: ДАРХАН ЦААЗАТ ОЙ ДАХЬ ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ,
ДАРАНГҮЙЛАЛ, УГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ

Эмнести Интернэшнл

гэрэлтүүлгийн зорилгоор ашиглаж, борлуулдаг бол завины чигжээс, будаг, лак, тэр ч бүү хэл сүрчигний найрлага болгон арилжааны зориулалтаар ашигладаг.⁴³

Диптерокарпус төрлийн мод нь хамгийн өндөр чанартай биш боловч арилжааны хувьд ихээхэн ашигтай. Хоёрдугаар зэрэглэлд багтдаг уг мод нь модон хавтан хийхэд нэн тохиромжтой учраас Камбожийн модны худалдаачдын дунд их эрэлттэй байдаг.⁴⁴

Прэй Прэяя Рока дахь давирхайн модыг ихэвчлэн ширээ, хаалга, таазны дам нуруу, сандал болон ор хийхэд ашигладаг. *Диптерокарпус алатус* (Кхмер хэлээр Чал Тиэл) болон *диптерокарпус криспалатус* (Кхмер хэлээр трач) зэрэг төрөл зүйлийн мод юм. Энэ хоёр зүйл нь хатуу, шулуун, зузаан их биетэй тул тавилга үйлдвэрлэхэд тохирдог учир мод бэлтгэгчдийн хувьд чухал хэрэгцээтэй байдаг.

Үргэлж ойгоос хамааралтай амьжиргаатай байсаар ирсэн хүмүүсийн хувьд ой устаж, улмаар хүмүүс амьдралын хэв маягаасаа хөндийрч байгаа нь амьжиргааны эх үүсвэр болон соёл, уламжлалаа хадгалж үлдэх хүчин чармайлтад их хор хөнөөл учруулж байгааг Эмнести Интернэшнлийн судлаачидтай ярилцсан бүх Куй хүн онцолж байв.

Давирхайн модыг хууль бусаар бэлтгэж байгаа нь Куй иргэдийн уламжлалт амьжиргаанд нүүрлэж буй томоохон аюулын нэг гэдгийг ярилцлага өгсөн хүмүүс байнга онцолж байлаа. Прэй Прэяя Рокагийн хүмүүсийн давирхайн моднууд сүүлийн арваад жилийн хугацаанд мод бэлтгэгчдийн хараанд өртөж байгаа бөгөөд нутгийн иргэдийн мэдээлснээр энэ нь Байгаль орчны яамнаас нутгийн иргэдийн байгууллагуудын ой хамгаалах үйл ажиллагаанд тавьсан хязгаарлалттай давхцах болов. Ярилцлага өгсөн нэг хүний мэдээлснээр:

10-15 орчим жилийн өмнө бол Бро Мегийн бараг бүх хүн, манай гэр бүл ч тэр зохих хэмжээний давирхай цуглуулдаг байлаа. Гэтэл одоо бидэнд юу ч алга... Хүмүүсийн ашигладаг байсан давирхайн мод одоо бүгд үгүй болсон.⁴⁵

Орлогын чухал эх үүсвэрийг нь булаан авснаас амьжиргаанд нь ихээхэн дарамт учрах болсон тухай нутгийн иргэд ярьж байлаа. Ярилцлагад оролцогчдын тайлбарласнаар, давирхай цуглуулах нь Прэй Вихеарийн Бро Ме нийгэмлэгийн хүмүүсийн хамгийн чухал, уламжлалт орлогын эх үүсвэрийн нэг байсаар иржээ (үхэр өсгөх болон газар тариалан эрхлэхийн хажуугаар). Тосгоны нэг гишүүн Чан Тидагийн хэлснээр, Прэй Прэяя Рока орчмын давирхайн модыг хууль бусаар огтлох явдал маш өргөн хүрээг хамарсан гэв.

Прэй Прэяя Рокагийн бүх давирхайн модны 60, 70 хувийг огтолсон, 30 орчим хувь нь л ойн гүндээ үлдсэн. Бро Мегийн гаднаас олон хүн ирж манай модыг хулгайлдаг. Биднийг ойд байхгүй үед, ялангуяа будаа тариалах, эсвэл хураах зэрэг тариалангийн завгүй үеэр хулгай хийдэг. Заримдаа өдөрт 30, 40 мод огтолж байж ч мэднэ.⁴⁶

Прэй Прэяя Рока бол давирхайн олборлолтын чухал бүс нутаг бөгөөд Бро Мегийн хүмүүсийн уламжлалт амьжиргааг хангадаг газар юм. Хүмүүс нэг литр давирхайнаас 40 мянган риел (10 ам.доллар) хүртэл, дунджаар 10 үржил шимтэй модноос нэг удаадаа 360 мянган риел (90 ам.доллар) хүртэл ашиг олох боломжтой. Тэрээр цааш нь, зарим Куй хүмүүс хууль бус мод бэлтгэлийн өмнө хүчин мөхсөдсөндөө өөрсдөө модоо тайрсан тухай ярилаа. "Зарим хүмүүс өөрийн давирхайн модоо тайрахыг илүүд үзэх боллоо, тэгээд тайрсан модоороо байшин барина, давирхайн модноос ядаж л ингэж ашиг хүртэнэ шүү дээ" гэж тайлбарлалаа.⁴⁷

Өөрсдөө давирхайн модоо тайрч хэрэглэж буй хүмүүс ч элдэв асуудалтай нүүр тулах болов. Байгаль орчны яамны байгаль хамгаалагчид эдгээр хүмүүсийг бай болгон буруутгаж, өөрсдийн хамаарал бүхий мод бэлтгэгчдэд ямар нэгэн ял шийтгэлгүйгээр ажиллах боломжийг олгодог байна. Тосгоны оршин суугч Чан Тида:

⁴³ Эванс болон бусад, "Давирхай олборлолт болон амьжиргааны талаарх судалгаа"

⁴⁴ Эванс болон бусад, "Давирхай олборлолт болон амьжиргааны талаарх судалгаа"

⁴⁵ Эмнести Интернэшнлийн Хор Дитай хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар.

⁴⁶ Эмнести Интернэшнлийн ЧанТидатай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар.

⁴⁷ Эмнести Интернэшнлийн Чан Тидатай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар.

Зарим хүмүүс өөрсдөө давирхайн модыг тайрах гэж яваад Байгаль орчны яамныханд ой устгасан хэргээр баривчлагдаж байна. Өдөр бүр мод огтлохоор ой руу очдог дотоодын цагаачид болон бусад хүмүүсийг Байгаль орчны яамныхан хөөж, баривчилж байхыг би хэзээ ч хараагүй. Харин яамны ажилтнуудад мөнгө өгөөгүй хүмүүсийг баривчилдаг, би өөрөө хүртэл байшин барих мод огтлохоор явж байгаад баривчлагдаж байсан. Харин манай давирхайн модыг хулгайлахаар очсон хүмүүс дандаа зүгээр мултарчихдаг⁴⁸ хэмээн тайлбарласан юм.

Прэй Лангт ч нөхцөл байдал адил байна. Ярилцлага өгсөн бүх Куй иргэн тэдний амьдардаг орчинд давирхайн мод устаж байгаа талаар болон энэ нь амьжиргаа, соёлд нь хэрхэн нөлөөлж байгааг онцлоод, заримдаа тосгоныхон нь давирхай цуглуулж огт чадахаа больсон тухай ч ярьж байв.⁴⁹ Прэй Лангийн зарим хэсэгт 2016 оноос хойш давирхайн мод алга болсон гэсэн мэдээ гарсан ба энэ нь Прэй Лангийг зэрлэг амьтан, ургамлын дархан цаазат газар болгосон жил юм.⁵⁰ Прэйяа Вихээр мужийн Ровиэнг дүүргийн нөхцөл байдал арай өөр бөгөөд “тэнд ямар ч давирхайн мод байхгүй, бүгд утсан байна.”⁵¹

Прэй Ланг дахь Куй иргэдийн ярьснаар, мод бэлтгэгчид заримдаа орон нутгийн иргэдээс давирхайн мод худалдаж авах санал тавьдаг. Гэхдээ ямартай ч мод огтлох нь гарцаагүй учир, тэд ямар ч үнэ санал болгосон хүлээн авахаас өөр сонголт бараг байхгүй. Кенг Хуот хэлэхдээ: “Мод бэлтгэлийн бүлгийн толгойлогчид бидэн дээр ирээд давирхайн модоо зарах уу гэж асуудаг. Үнэн хэрэгтээ бид түүнд зарахгүй бол тэд өөрсдөө ирээд авах л болно. Тэд маш бага үнэ санал болгодог, нэг мод ердөө 10 – 20 мянган риел (2,5-5 ам доллар) хүрдэг”.⁵²

Кратийн Самбор дүүргийн хүмүүс мөн давирхайн модоо алдах асуудалтай нүүр тулаад байна. Орон нутгийн нэгэн иргэн:

Энэ нь бидний амьжиргаанд маш их нөлөө үзүүлж байна. Ой сүйдэж, ялангуяа манай давирхайн мод устаж, бараг хүн бүр давирхайн модоо алдаж байна. Би үлдсэн давирхай болон модоо хамгаалах гэж хамаг чадлаараа зүтгэж байна, би хэнээр ч эднийгээ тайруулахгүй. Гэхдээ Байгаль орчны яам бидэнд үргэлж тээг болж, ойгоо идэвхтэй хамгаалахад саад болоод байгаа учир ийм хүчин чармайлт гаргахад үнэхээр хэцүү юм⁵³ гэсэн юм.

Давирхайнаас гадна, модон бус, ойн дагалдах баялаг ихээхэн хомсдож байгаа талаар орон нутгийн иргэд мэдээлсэн байна.⁵⁴ *Пли гоу, пли сэ моан* зэрэг улирлын жимснүүд Куй иргэдийн түүж, хүнсэндээ хэрэглэдэг, орон нутгийн зах дээр зарж борлуулдаг ойн чухал дагалдах баялгийн нэг юм. Эдгээр жимс нь зөвхөн ойд ургадаг, орон нутгийн амтанд тооцогддог байна.

Тосгоны зарим хүмүүсийн тооцоолсноор өнгөрсөн жилүүдэд ойд нэг, хоёр өдөр яваад, эдгээр жимсийг хангалттай хэмжээнд түүж, 100 мянган риел (ойролцоогоор 25 ам.доллар) олох боломжтой байсан гэнэ. Энэ жимснүүдийн мод одоо нилээн ховордож, мод бэлтгэлийн улмаас Прэй Прэйяа Рокагийн орчмоос олоход бэрх болсон тухай ярилцлага өгсөн бүх хүн хэлж байв. Ярилцлага өгсөн нэг хүний хэлснээр бол:

Энэ ой модод ойн цоорхой шиг л болсон байна – ямар ч том мод байхгүй, ойн дагалт баялаггүй болсон. Өмнө нь Пли гой орлого олдог чухал зүйл байсан, бид ид ургацынх нь үед хэдэн зуун мянган риелийн орлого олдог байлаа, одоо бол олдохоо больсон⁵⁵ байна.

Прэй Прэйяа Рокагийн нэгэн адил, Прэй Лангийн мод бэлтгэлийн нутгийн иргэд амьжиргаанд үзүүлж буй нөлөөлөл зөвхөн давирхайн модны хомсдолоор зогсохгүй, Пли гой, Пли се моан

⁴⁸ Эмнести Интернэшнлийн Чан Тидатай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар.

⁴⁹ Жишээ: Эмнести Интернэшнлийн Кем Дутай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар, Эмнести Интернэшнлийн Кэнг Хуоттой хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар.

⁵⁰ Эмнести Интернэшнлийн Кем Дутай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар.

⁵¹ Эмнести Интернэшнлийн Хуоттой хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар.

⁵² Эмнести Интернэшнлийн Кенг Хуоттой хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар.

⁵³ Эмнести Интернэшнлийн Ту Чанглтай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар.

⁵⁴ Эмнести Интернэшнлийн Чан Самбаттай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар, Эмнести Интернэшнлийн Хор Дутай хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар.

⁵⁵ Эмнести Интернэшнлийн Чан Самбаттай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар.

БИДНИЙ УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫГ УСТГАЖ БАЙНА

**КАМБОЖ: ДАРХАН ЦААЗАТ ОЙ ДАХЬ ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ,
ДАРАНГҮЙЛАЛ, УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ**

Эмнести Интернэшнл

зэрэг улирлын чанартай жимснүүд, мөн зөгийн сархинаг, нишингийн мөөг, болон усан үзэм ч олдоц муутай болсон байна. Чиэ Сэн дүүргийн хувьд:

Одоо ойн дагалдах баялаг ч байхгүй устаж, үгүй болсон. Мөн ойн амьтад цөм байхгүй болсон. Мод бэлтгэгчдийн огтлодог давирхайн модон дээрх зөгийн үүр сүйрч, зөгийн сархинаг хүртэл олдоход бэрх болсон. Энэ бүс нутагт зөгий үүрээ барихаа больсон, үүр нь хол байгаа учир бид зөгийн бал цуглуулах боломжгүй болсон.⁵⁶

Прэй Лангийн эргэн тойронд амьдардаг орон нутгийн иргэдийн Эмнести Интернэшнлд өгсөн ярилцлагаас харахад тэд дөнгөж саяханыг хүртэл ойн мод бус дагалт баялгаас ихээхэн хамааралтай амьдарч байжээ. Орлогын ийм эх үүсвэрээ алдсан хүмүүс ажил хайж цагаачлах, тэр ч байтугай ерөнд орсон байна. Амьжиргааны цөөхөн эх үүсвэртэй хүмүүс устаж буй ойд дагалт баялаг хайж, их хэмжээний цаг зарцуулахаас өөр аргагүй болжээ:

Түүнчлэн ойн мод бус дагалт баялаг ч хомсдох томоохон асуудал тулгараад байна. Саяхан би ойд хэдэн шөнийг өнгөрөөж, ердийн дагалт баялаг олохын тулд өмнөхөөсөө илүү хол явах шаардлагатай болсон, олсон зүйл маань ч хариугүй жаахан байсан. Хэдэн жилийн өмнө хүмүүс далдуу модны сахар (цэвэршүүлээгүй далдуу модны сахар) зэрэг ойн баялгийг 10 кг хүртэл цуглуулж чаддаг байсантай харьцуулахад нөхцөл байдал эрс өөр болоод байна. Одоо уур амьсгал илүү хуурай болж, мод бэлтгэлээс болоод ой сүйдэж байхад хүмүүс нэг удаагийн явалтаар зөвхөн 400-500 граммыг л олж байна. Өмнө нь бид ойн дагалдах баялгаас амьжиргаагаа залгуулдаг байсан учир энэ нь хүмүүсийн орлогод сөрөг нөлөө үзүүлэх боллоо.⁵⁷

Орон нутгийн иргэдийн ойн болон ойн дагалт нөөц баялгийг ашиглах уламжлалт эрхийг 2008 оны Тусгай хамгаалалттай газрын тухай хууль, 2002 оны Ойн тухай хууль, 1996 оны Байгаль орчныг хамгаалах, Байгалийн нөөцийн менежментийн тухай хууль болон 2001 оны Газрын тухай хуулиар хүлээн зөвшөөрсөн.

Уугуул иргэдийн эрхийн тухай НҮБ-ын тунхаглал 20-р зүйлд мөн нутгийн уугуул иргэд “өөрийн амьжиргааны болон хөгжлийн арга замаа хамгаалах, уламжлалт болон бусад эдийн засгийн үйл ажиллагаанд чөлөөтэй оролцох” эрхийг хүлээн зөвшөөрсөн ба Камбожийн эрх баригчид энэхүү эрхийг хамгаалах үүрэгтэй. Цаашлаад 20.2 дахь хэсэгт, “Нутгийн уугуул иргэд хөгжлийн болон амьжиргааны эх үүсвэрээсээ салсан бол тэд шударга, тэгш байдлаар хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй” гэж заасан байдаг.


Тиймээс Камбожийн эрх баригчид дотоодын болон олон улсын хууль тогтоомжийн дагуу нутгийн уугуул иргэдийн уламжлалт байдлаар амьжиргаагаа залгуулж ирсэн ойг хамгаалах үүрэгтэй. Дээр дурдсан нотолгоонуудаас үзэхэд, хууль бус мод бэлтгэл болон Засгийн газрын хязгаарлалт нь Куй иргэдийн амьжиргаандаа зориулан давирхай олборлох, ойн дагалт нөөц ашиглах боломжийг үлэмж хэмжээгээр бууруулжээ. Прэй Ланг болон Прэй Прэяа Рокагийн зарим хэсэгт амьдралын ийм хэв маяг бүрэн устсан байна. Дараагийн хэсэгт дурдсанчлан, энэхүү устгалд Байгаль орчны яамны албан тушаалтнууд хууль бус модны наймааны авлигад автсан нь ихээхэн нөлөө үзүүлжээ.

ОИГ.МН
СУДАЛГААНЫ САН

⁵⁶ Эмнести Интернэшнлийн Кем Дутай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар.

⁵⁷ Эмнести Интернэшнлийн Сам Арунтай хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар.

2.3 ОЙН УСТГАЛЫГ ЗАЙНААС ТАНДАН СУДЛАХ НЬ



Эмнести Интернэшнл болон Спэйс4Гүүд (Space4Good) зайнаас тандан судлах байгууллагын тооцоолсноор, 2021 онд Прэй Ланг болон Прэяя Рокагийн хамгаалалттай газрын багаар бодоход 6,271 га (8,784 хөл бөмбөгийн талбайтай тэнцэх газар) газарт ой устсан байна. Энэхүү судалгаанаас харахад Прэй Ланг болон Прэяя Рокад сүүлийн 12 сарын хугацаанд багаар бодоход 6,026 га, 246 га газрын ой (тус тус) устжээ. Энэхүү тайланд Сентинел-1 болон Планетскопоос авсан зайнаас тандан судлах нэгдсэн өгөгдлийг ашиглав.⁵⁸

Нэмэлт мэдээлэл авах боломжууд бий болсноор ой устгалтын талаарх илүү их мэдээлэл олдох магадлал өндөр байна.⁵⁹

2.4 ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ ДЭХ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ОРОЛЦОО

2021 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Камбож дахь АНУ-ын Элчин сайдын яам “Прэй Лангийн ногооруулах нь” гэдэг нэртэй хэрэгжүүлсэн байгаль хамгаалах төслийн санхүүжилтээ буцаан татаж, гэрээнээс татгалзаж байгаагаа мэдэгдсэн. Байгаль орчны яаманд байгаль хамгаалах үйл ажиллагаа явуулахад нь зориулж 21 сая ам.долларын санхүүжилт олгосон байжээ. Тэрхүү мэдэгдэлд:

⁵⁸ Арга зүйн талаарх дэлгэрэнгүй тайлбарыг Space4Good, Камбож дахь ойн устгал. 2022 оны 1 сарын 24, хуулбар Эмнести Интернэшнл-с үз.

⁵⁹ Өөр байгууллагууд Прэй Ланг, Прэй Прэяя Рока дахь ойн устгалын талаар тогтмол хяналт үнэлгээ хийж байна. Жишээ нь, Дэлхийн Ойн Хяналт байгууллага зайнаас тандан судлах мэдээлэлд үндэслэн модны бүрхэвч, модны бүрхэвчийн хомсдол, ойн ерөнхий хомсдолын талаар жил бүр тоон мэдээлэл нийтэлдэг. www.globalforestwatch.org-с үзэж болно. Прэй Ланг Нутгийн иргэдийн Сүлжээнээс зайнаас тандан судлах шинжилгээг оруулаад, Прэй Лангийн хяналт үнэлгээний тогтмол тайланг нийтэлдэг. <https://preylang.net/resources/monitoring-reports/> с үз.

2016 оноос хойш АНУ-ын ОУХА (USAID) байгаль хамгаалагч, эргүүлүүдийг нэмэгдүүлэх, хууль сахиулах байгууллагын албан хаагчдыг сургах, үндэсний тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн боловч Прэй Лангийн дархан цаазат газар ойролцоогоор 38,000 га ой буюу нийт ойн бүрхэвчийнхээ бараг 9 хувийг алдсан байна.⁶⁰

Уг мэдэгдэлдээ Камбожийн эрх баригчид хууль бус мод бэлтгэл болон байгаль хамгааллын эсрэг гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа хангалтгүй байгаа нь орон нутгийн идэвхтэнүүдийн үйл ажиллагааг хязгаарлаж байгааг онцолжээ. Уг мэдэгдэлд:

Камбожийн эрх баригчид байгаль хамгааллын эсрэг гэмт хэргийг зохих ёоор мөрдөн шалгаж, эдгээр хууль бус ажиллагааг таслан зогсоож чадаагүй. Түүнчлэн Засгийн газар байгалийн баялгаа алдаж байгаадаа сэтгэл зовинож буй орон нутгийн иргэд, иргэний нийгмийн идэвхтнүүдийг онилж, амыг нь тагласаар байна⁶¹.

Хэдэн сарын дараа буюу 2021 оны 11 дүгээр сард АНУ-ын ОУХА болон Тетра Тек ("Прэй Лангийг ногоорууля" төслийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн АНУ-д төвтэй байгууллага) төслийнхөө 2021 оны жилийн тайланг хэвлүүлэв.⁶² Уг тайланд Камбожийн Байгаль орчны яам, бусад албан хаагчид руу 2019 оны 5 дугаар сараас 2021 оны 8 дугаар сарын хооронд илгээж байсан 29 удаагийн тайлангаас дэлгэрэнгүй оруулжээ. "Прэй Лангийг ногоорууля" төслийн Засгийн газрын бүх санхүүжилтийг буцаан татах АНУ-ын ОУХА-ийн эцсийн шийдвэр нь "Прэй Лангд үйлдвэрлэлийн зориулалтаар их хэмжээний хууль бус мод бэлтгэл системтэйгээр явагдаж байгаа тухай" нотлох баримтуудад Камбожийн эрх баригчид зохих ёсоор хариу өгч, ажиллаагүйтэй холбоотой бололтой.⁶³

Прэй Ланг болон Прэй Прэяа Рока дахь хууль бус мод бэлтгэлтэй холбоотой явуулсан хяналт шалгалтаас харахад төрийн албан хаагчдын оролцсон авлига, хууль бус худалдааг хөнгөвчлөхөд ихээхэн үүрэгтэй байсан нь ажиглагдаж байна.⁶⁴ Хэдийгээр мод бэлтгэдэг бүлэглэлүүд, хөдөө аж ахуйн бизнес эрхэлдэг компаниудыг уг хууль бус худалдааг удирддаг гэж харддаг боловч мод бэлтгэгчдийг хамгаалж, орон нутгийн хамгаалалттай ойд нэвтрүүлдэг Байгаль орчны яамны байгаль хамгаалагчид, цагдаагийн дэмжлэггүйгээр тэд хууль бус үйл ажиллагаагаа явуулж чадахгүй. 2021 оны 11 дүгээр сард АНУ-ын ОУХА болон Тетра Текийн гаргасан тайланд Прэй Лангийн дархан цаазтай газарт хууль бусаар мод бэлтгэхтэй холбоотой асуудлаар Байгаль орчны яамны албан тушаалтнууд авлигад холбогдсон тухай баримт мэдээллийг дурдсан.⁶⁵

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх Дэлхийн нийтийн санаачилга байгууллагаас тэдний холбоосыг дараах байдлаар тодорхойлжээ. "Камбожийн хууль бус мод бэлтгэлийн хэв маяг нь гэмт хэргийн үйлдлээс хамаагүй илүү нарийн, энэ бол төрийн албан хаагчид болон Окнха (улс орны хөгжилд зориулж Камбожийн засгийн газарт их хэмжээний

⁶⁰ АНУ-ын Камбожид ажилласан баг. "АНУ-ын Пном Пенн дэх Элчин сайдын яамны АНУ-ын ОУХА-ын Прэй Лангийг ногооруулах төслийн санхүүжилтийг өөрчлөв", 2021 оны 6 сарын 17, kh.usembassy.gov/u-s-embassy-phnom-penh-statement-on-the-usaid-greening-prey-lang-funding-redirect

⁶¹ АНУ-ын Камбожид ажилласан баг. "АНУ-ын Пном Пенн дэх Элчин сайдын яамны АНУОУХА-ын Прэй Лангийг ногооруулах төслийн санхүүжилтийг өөрчлөв" /өмнө дурдсан/

⁶² АНУ-ын ОУХА болон Тетра Тек, "АНУ-ын ОУХА Прэй Лангийг ногоорууля төслийн Жилийн тайлан#3, 2020 оны 10 сарын 1-с 2021 оны 9 сарын 30", 2021 оны 11 сар. https://dec.usaid.gov/dec/content/Detail_Presto.aspx?ctID=ODVhZjk4NWQtM2YyMi00YjRmLTkxNjktZTcxMjM2NDNmY2Uy&riD=NTk0MjY0&inr=VHJ1ZQ%3d%3d&dc=YWRk&rrtc=VHJ1ZQ%3d%3d&bckToL=

⁶³ АНУ-ын ОУХА болон Тетра Тек, "АНУ-ын ОУХА Прэй Лангийг ногоорууля төслийн Жилийн тайлан#3, 2020 оны 10 сарын 1-с 2021 оны 9 сарын 30", 2021 оны 11 сар. https://dec.usaid.gov/dec/content/Detail_Presto.aspx?ctID=ODVhZjk4NWQtM2YyMi00YjRmLTkxNjktZTcxMjM2NDNmY2Uy&riD=NTk0MjY0&inr=VHJ1ZQ%3d%3d&dc=YWRk&rrtc=VHJ1ZQ%3d%3d&bckToL=, хуудас 121.

⁶⁴ Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг дэлхий нийтийн санаачилга, Камбож дахь ойн гэмт хэрэг: Прэй Лангийн дархан цаазат газар дахь хууль бус ажиллагааны тойрог, 2021 оны 3 сарын 26, globalinitiative.net/analysis/forest-crimes-cambodia, Глобал Витнес, Камбожийн гэр бүлийн мод, 2007 оны 5 сарын 31, globalwitness.org/en/reports/cambodias-family-trees; Байгаль орчны мөрдөн шалгах агентлаг /БОМША/, Цуврал хэргүүд: Вьетнам Камбожийн хууль бусаар бэлтгэсэн модыг импортоор авсан хэвээр байна, 2018 оны 5 сарын 31, eia-international.org/wp-content/uploads/eia-serial-offender-web.pdf; БОМША, Давтан гэмт хэрэг: Вьетнамын хууль бус мод бэлтгэлийн тогтмол наймаа, 2017 оны 5 сарын 8, eia-international.org/wp-content/uploads/Repeat-Offender.pdf

⁶⁵ АНУ-ын ОУХА болон Тетра Тек, "АНУ-ын ОУХА Прэй Лангийг ногоорууля төслийн Жилийн тайлан#3, 2020 оны 10 сарын 1-с 2021 оны 9 сарын 30", 2021 оны 11 сар. https://dec.usaid.gov/dec/content/Detail_Presto.aspx?ctID=ODVhZjk4NWQtM2YyMi00YjRmLTkxNjktZTcxMjM2NDNmY2Uy&riD=NTk0MjY0&inr=VHJ1ZQ%3d%3d&dc=YWRk&rrtc=VHJ1ZQ%3d%3d&bckToL= Хавсралт 6.

мөнгө хандивласан, харилцаа холбоо сайтай бизнес эрхлэгчдэд олгодог хүндэтгэл) нарын бүтээсэн авилгад идэгдсэн зохион байгуулалттай сүлжээ бөгөөд тэд уг сүлжээнээсээ ял завшин, ашиг хүртдэг.⁶⁶

Судалгааны явцад Эмнести Интернэшнлийн цуглуулсан баримтууд дээрх төрлийн нотолгоонуудыг улам бүр нэмсээр байна.⁶⁷

Прэй Ланг болон Прэй Прэйяа Рокагийн орчмын орон нутгийн иргэд Байгаль орчны яамны албан хаагчид болон орон нутгийн цагдаа нар хууль бус модны наймаанд оролцдог талаар Эмнести Интернэйшнлийн ажилтнуудад байнга хэлж байлаа. Мод бэлтгэгчид болон модны наймаачдаас авлига авсан албан хаагчид хариуд нь хууль бус мод бэлтгэлийг нүдээ аньж өнгөрөөгөөд, тэдний үйл ажиллагааг хөнгөвчилж өгдөг тухай мэдээлэл байна. Байгаль орчны яамны албан тушаалтнууд зөвхөн өөрсдөд нь авлига өгөөгүй мод бэлтгэгчдийг л хариуцлагад татдаг тухай ярилцлага өгсөн хүмүүс байнга ярьж байв.

Жишээ нь, Прэйяа Вихеарын Бро Ме-оосирж ярилцлага өгсөн зарим хүмүүсийн хэлснээр ийм авлига ил цагаан, өдөр бүр болдог⁶⁸ гэв. Тосгоны нэг хүний хэлснээр, өдөрт 5-15 трактор, эсвэл үхэр тэрэг модыг тэдний тосгон руу тээвэрлэж байв. Мөн Ковид-19 цар тахлын хөл хорионы үед хүртэл Бро Ме-д мод бэлтгэл зогсолтгүй үргэлжилсэн.⁶⁹ Бро Мегийн зарим хүмүүсийн хэлснээр Байгаль орчны яамны албан тушаалтнууд Яамны байгаль хамгаалагчийн станцыг дайран өнгөрсөн трактор бүрийн төлбөрийг албан бусаар хураахын тулд мод бэлтгэлийг зөвшөөрч байх шиг байна гэж мэдэгдлээ.

Мод бэлтгэгчдийн Байгаль орчны яаманд төлж буй төлбөр нь дунджаар нэг трактор ачаанд 30 мянган риел (7.50 ам. доллар) байдаг гэнэ. Зарим хүмүүсийн хэлснээр, мод бэлтгэгчид орон нутгийн Байгаль орчны яамны албан тушаалтнуудад сар бүр хураамж төлдөг байна.⁷⁰

Тосгоны нэгэн оршин суугч Прэй Вихеар мужийн зарим төрийн албан хаагчид хууль бус үйл ажиллагаа, дээрэм тонуул хийхдээ нууж хаах зүйлгүй, ичгүүр сонжуургүй авирладаг талаар ярьсан юм:

Мод бэлтгэгчдээс мөнгө хураах гээд зам дээр зогсож байгаа энэ бүх цагдаа нарыг хараад бүр гайхах юм. Яаж ийм ичгүүргүй байж чаддаг байна аа. Байгаль орчны яам ойг хариуцах ёстой газар биш билүү. Заримдаа яамныхан ойн эргүүлд гарч тойроод байж байхад хүртэл цагдаа нар мод бэлтгэгчид руу утасдаад – Та санаа зовох зүйлгүй, ойгоос модоо аваад гар, танд ямар ч асуудал тулгарахгүй гэж хэлдэг.⁷¹

Прэй Прэйяа Рокагийн нөхцөл байдалтай нэгэн адил Прэй Ланг дахь судалгаанд оролцсон бүх хүмүүс цагдаа нар хууль бус модны наймаанд оролцож, Байгаль орчны яам мод бэлтгэх болон авлига авах явдлыг үл тоож байна гэж мэдэгджээ. Нэг иргэний хэлснээр:

Албан тушаалтнууд, ялангуяа Байгаль орчны яамныхан зөвхөн мөнгө хураах л сонирхолтой байдаг нь том асуудал юм. Би Яамны орон нутгийн оффист очиж, мод бэлтгэлийн тухай мэдээллээд гэрэл зураг болон бусад нотлох баримтуудыг өгөх гэж олон удаа оролдсон. Гэвч тэд мод бэлтгэгчдээс мөнгө авахын тулд л

⁶⁶ Үндэстэн дамнансан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг дэлхий нийтийн санаачилга, Камбож дахь ойн гэмт хэрэг: Прэй Лангийн дархан цаазат газар дахь хууль бус ажиллагааны тойрог, 2021 оны 3 сар, globalinitiative.net/wp-content/uploads/2021/03/Forest-crimes-in-Cambodia-Rings-of-illegality-in-Prey-Lang-Wildlife-Sanctuary-GITOC-2021.pdf, хуудас 38.

⁶⁷ Үндэстэн дамнансан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг дэлхий нийтийн санаачилга, Камбож дахь ойн гэмт хэрэг: Прэй Лангийн дархан цаазат газар дахь хууль бус ажиллагааны тойрог, 2021 оны 3 сарын 26, globalinitiative.net/analysis/forest-crimes-cambodia, Глобал Витнес, Камбожийн гэр бүлийн мод, 2007 оны 5 сарын 31, globalwitness.org/en/reports/cambodias-family-trees; Байгаль орчны мөрдөн шалгах агентлаг /БОМША/, Цуврал хэргүүд: Вьетнам Камбожийн хууль бусаар бэлтгэсэн модыг импортоор авсан хэвээр байна, 2018 оны 5 сарын 31, eia-international.org/wp-content/uploads/eia-serial-offender-web.pdf; БОМША, Давтан гэмт хэрэг: Вьетнамын хууль бус мод бэлтгэлийн тогтмол наймаа, 2017 оны 5 сарын 8, eia-international.org/wp-content/uploads/Repeat-Offender.pdf

⁶⁸ Эмнести Интернэшнлийн Ду Вутитай хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар, Эмнести Интернэйшнлийн Чан Самбаттай хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар, Эмнести Интернэйшнлийн Кем Дутай хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар.

⁶⁹ Эмнести Интернэшнлийн Кем Дутай хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар.

⁷⁰ Эмнести Интернэшнлийн Ду Вутитай хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар, Эмнести Интернэйшнлийн Чан Самбаттай хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар,

⁷¹ Эмнести Интернэшнлийн Лин Борамэйтэй хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар.

шалгадаг. Хэд хоногийн дараа нөгөө хүмүүс дахиад л мод огтолдог.⁷²

Прэй Вихеар мужийн Прэй Лангийн ойролцоо амьдардаг тосгоны нэг иргэн ингэж хэлэв:

6 сараас хойш (2021) Байгаль орчны яам болон дархан цаазат газрын албан ажилтнууд мод бэлтгэгчидтэй хамтарч байгаа тохиолдол хэд хэдэн удаа гарах шиг боллоо. Бид тэднийг мод бэлтгэж байх үед нь очиж зураг, оролцсон хүмүүсийнх нь нэрийг өгсөн, тэр хүмүүстэй хариуцлага тооцно гэж амласан. Гэвч зураг баримтыг аваад тэгээд юу ч хийлгүй таг болсон доо.⁷³

Прейяа Вихеарын ойтой мужийн нэг оршин суугч мөн л ижил зүйл ярилаа:

Албан хаагчид ачааны машины замыг хамгаалдаг. Би ямар ч албан хаагч, ялангуяа Байгаль орчны яамнаас мод бэлтгэлтэй холбоотой арга хэмжээ авч байхыг хараагүй. Яамнаас биднийг хянаж, эргүүл хийх зэргээр ойд ямар нэг үйл ажиллагаа явуулахыг хориглодог.

Төрийн байгууллага тэнд ажиллаж байгаа хэмээн шалтаглаж биднийг ой руу орохыг буруушаадаг. Биднийг мод бэлтгэлийн машин болон мод бэлтгэлийн бусад үйл ажиллагааны зургийг авбал баривчилж, шоронд хийнэ гэж сүрдүүлдэг⁷⁴ гэлээ.

Камбожийн төрийн албан тушаалтнууд хувийн хэвшлийнхний хууль бус мод бэлтгэлийг хориглож, зогсоож чадахгүй байгаа нь Прэй Ланг болон Прэй Прэй Рокаг хамгаалахад ноцтой хохирол учруулж, мөн тус улсын засгийн газар иргэдийнхээ нутгийн уугуул иргэдийн хувьд эдлэх эрхийг хамгаалах үүргээ биелүүлж чадахгүй байгаа нь илэрхий байна. Төрийн албан хаагчдын модны наймаатай холбоотой авлигад өртсөн тухай мэдээлэл тогтмол ирсээр байгаа нь Камбожийн албан тушаалтнууд байгаль хамгаалах үйл ажиллагаандаа шинэ арга барилаар ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

⁷² Эмнести Интернэшнлийн Тай Чанлитай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар.

⁷³ Эмнести Интернэшнлийн Хок Лимтай хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар.

⁷⁴ Эмнести Интернэшнлийн Чиа Соттой хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар.

3. НӨХӨН СЭРГЭЭЛТ НЭРЭЭР ДАРАНГУЙЛЖ БАЙНА: КАМБОЖИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМ НУТГИЙН УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙГ ЗӨРЧИЖ БАЙГАА НЬ

Хууль бус мод бэлтгэл, авлига нь Камбожийн тусгай хамгаалалттай ойд сөрөг нөлөө үзүүлэхийн зэрэгцээ байгаль орчны асуудал хариуцсан албан тушаалтнуудаас хараат бус байгаль орчны идэвхтэнүүд, ой хамгаалагчид, нутгийн уугуул иргэдийг дарамтлах явдал огцом нэмэгдээд байна. Энэхүү дарангуйлал сүүлийн хоёр жилд илүү даамжирч, байгаль хамгаалахтай холбоотой асуудлуудыг байгаль орчны идэвхтэнүүдийг гадуурхах, дарамтлах явдлаа зөвтгөхийн тулд ашиглах болов.

2020 оны 2 дугаар сарын 22-ны өдөр, Прэй Лангийн ойн эргэн тойронд Байгаль орчны яамнаас илгээсэн зэвсэгтэй хамгаалагчид хаа сайгүй явж, Прэй Лангийн Орон нутгийн иргэдийн холбооноос жил бүр зохион байгуулдаг мод ерөөх ёслолд уг холбооны гишүүд болон лам нарыг оролцохыг хориглож, заримыг нь түр саатуулсан байна. Ёслолыг тарааж, оролцогчдыг Прэй Лангийн хамгаалалттай бүсийн зарим хэсэгт нэвтрэхийг хоригложээ.⁷⁵

Мод ерөөх ёслол нь Куй иргэдийн соёл, сүсэг бишрэлийн хувьд ч, Прэй Лангийг хамгаалах тэдний хүчин чармайлтын хувьд ч тэр ихээхэн чухал үйл явдал юм. ПЛОНИС жил бүр болдог уг ёслолыг тайлбарлахдаа ойролцоох нутаг дэвсгэр, ой модыг хамгаалдаг, уул, хөндий, гол горхины сүнснүүд биднийг амар амгалан байлгаж, хөгжин цэцэглүүлж байдаг тул ёслол хийдэг. Уг ёслол бол үе уламжлагдан ирсэн чавхдаст хөгжим, нум, бөмбөр зэрэг уламжлалт хөгжмийн зэмсгүүдийг ашиглан, тосгоны өндөр настнууд, эцэг эхчүүд болон бусад хүмүүс оролцдог ёслол юм.⁷⁶

⁷⁵ Эмнести Интернэшнлийн, Камбож: Ой хамгаалагчдад ирж буй дарамт уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцлийг сулруулж байна (Индексийн дугаар: ASA 23/2004/2020), 2020 оны 3 сарын 20, [amnesty.org/en/documents/asa23/2004/2020/en](https://www.amnesty.org/en/documents/asa23/2004/2020/en), Камбожийн Хүний эрхийг хамгаалах, дэмжих бүлэг, "Албан тушаалтнууд нутгийн иргэдийн үйл ажиллагаанд саад хийж байгаа нь Прэй Лангийг хамгаалахад хохирол учруулж байна", 2020 оны 2 сарын 25, [licadho-cambodia.org/pressrelease.php?perm=448](https://www.licadho-cambodia.org/pressrelease.php?perm=448)

⁷⁶ ПЛОНИС, 2014 оны тайлан, 2014, https://preylang.net/wpcontent/uploads/Other%20reports/commune_report_2014.pdf, хуудас.27



Байгаль орчны яамны Кампонг Том дүүрэг дэх байгаль хамгаалагчид ПЛОНИС-ний гишүүдийг жил бүрийн мод ерөөх ёслолд оруулахгүй байгаа нь. 2020 оны 2 сарын 25.

ПЛОНИС-г Прэй Лангад эргүүл хийхийг хориглосны дараа тэд ийм мэдэгдэл гаргажээ:

Байгаль орчны яамнаас ПЛОНИС-г эргүүл хийхийг хориглосноос хойш мод бэлтгэгчид ойд чөлөөтэй нэвтэрч, тансаг сайхан моддыг маань огтолж аваад ойгоос зөөж, байгаль хамгаалагчдын шалган нэвтрүүлэх цэг дээр хураамж төлж (Прэй Лангийн дархан цаазтай газарт гэмт хэрэг үйлдэх зөвшөөрөл авсаныхаа хариуд) байна.⁷⁷

2020 онд ППРОНИС-ээс Прэй Прэяя Рокагийн 1000 модонд сахил хүртээх мод ерөөх ёслолыг амжилттай зохион байгуулж, тэднийг огтлуулахаас хамгаалахыг оролджээ. Ёслолд 100 гаруй хүн оролцож, орон нутгийн албан тушаалтнууд дэмжихээ илэрхийлсэн байна. Гэвч, түүнээс хойш сахил хүртээсэн модны ихэнхийг нь огтолж, ППРОНИС болон Байгаль орчны яамны бүхий л хамтын ажиллагаа зогссон. 2021 он гэхэд мод бэлтгэл өргөн хүрээнд явагдаж, орон нутгийн засаг захиргаа, тэр дундаа Байгаль орчны яамнаас орон нутгийн иргэдийн бүлгүүд, ялангуяа гаднаас хууль бус мод бэлтгэлд хяналт тавихаар гаднаас ирсэн хүмүүсийн үйл ажиллагаанд саад учруулах ажлыг идэвхтэй хийх болжээ.

2020 онд ПЛОНИС-ний модны ёслолыг зогсоосон нь Камбожийн Байгаль орчны яамны байгаль хамгаалах нэрээр явуулж буй дарангуйллын шинэ эрин үеийн эхлэл болов. Удалгүй, 2020 оны 3 дугаар сард Голдмэний Байгаль орчин хамгааллын шагналт Оуч Лэн баривчлагдаж, ПЛОНИС-ний гишүүд болох Срэй Тэй, Кэм Соку болон ойн мөрдөн байцаагч Ман Мат нарын хамт хоригджээ. Дараа нь Самбор дүүргийн цагдаагийн хэлтэст саатуулагдаж байх үед нь тус баривчилгааг эсэргүүцсэн олон нийтийн жагсаал Крати хотод олон хоног үргэлжилсэний дараа тэднийг ямар нэгэн ял шийтгэл оногдуулалгүйгээр сулласан байна.⁷⁸

Байгаль хамгаалах үйл ажиллагаанд дарамт учруулах нь сүүлийн хоёр жил мэдэгдэхүйц нэмэгдсэн хэдий ч нь Камбожийн хувьд огт шинэ зүйл биш юм. 2012 оны 4 дүгээр сард байгаль орчны нэрт идэвхтэн Чут Ватти Кох Конг мужид хууль бусаар мод бэлтгэсэн хэргийг шалгаж явахдаа цагдаад буудуулж амиа алдсан юм. Тэрээр Прэй Лангийг хамгаалах үйл хэргээрээ алдаршсан бөгөөд ПЛОНИС-тэй байгуулагдсан цагаас нь нягт хамтран ажилладаг байв. Ваттигийн аллагад хэн ч хариуцлага хүлээгээгүй, түүний гэр бүл энэхүү аллагын ард Камбожийн

⁷⁷ ПЛОНИС, "Прэй Лангийн дархан цаазат газарт хууль бус ойн устгал үргэлжилсээр байна", 2021 оны 2 сар. <https://preylang.net/wp-content/uploads/2021/02/9th-Monitoring-Report.pdf>, хуудас.13.

⁷⁸ Эмнести Интернэшнлийн, Камбож: Ой хамгаалагчдад ирж буй дарамт уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцлийг сулруулж байна (өмнө ишилсэн), [amnesty.org/en/documents/asa23/2004/2020/en](https://www.amnesty.org/en/documents/asa23/2004/2020/en)

хэн нэгэн нэр нөлөө бүхий хүн байгаа гэж хардсаар өдийг хүрчээ.⁷⁹

Мөн ПЛОНИС-ний бусад гишүүд ч хүчирхийлэлд өртөж, тэдний амь насанд заналхийлж байжээ. 2016 оны 3 дугаар сард ПЛОНИС-ний хүний эрх хамгаалагч эмэгтэй Фон Софеакыг Прэй Лангид ойн эргүүл хийгээд амарч байхад нь үл таних этгээдүүд сүх барьж дайрсан байна.⁸⁰ ПЛОНИС энэ халдлагыг хүний амь хөнөөхийг завдсан хэрэг гэж үзсэн.⁸¹ Халдлагыг огт мөрдөн шалгаагүй.

ПЛОНИС-ийн гишүүдийг дур зоргоороо баривчлах, хуулиар далайлгаж сүрдүүлэх зэргээр заналхийлж байв. 2021 оны 10 дугаар сарын 11-нд ПЛОНИС-ийн идэвхтэн Чан Тхөнийг “хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар санаатай хүчирхийлэл үйлдсэн” хэмээн буруутгаж, Эрүүгийн хуулийн 217, 218 дугаар зүйлд зааснаар 2 жилийн тэнсэн харгалзах ял оноожээ. Түүнийг 2020 оны 7 дугаар сард ойн эргүүл хийж байхдаа Прэй Лангийн дархан цаазат газраас хууль бусаар мод тээвэрлэж явсан ачааны машины зургийг авсаны дараа тус ялыг оноосон юм.⁸²

ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛЖ БҮЙ ДАРАМТ


Тус сүлжээний гишүүдийг дархан цаазат газарт зөвшөөрөлгүйгээр нэвтрэхийг хориглосон Байгаль орчны яамны байр суурь нь бусад идэвхтэнүүд, нутгийн иргэд, тэр ч байтугай суралцах, аялал, байгаль хамгаалах үйл ажиллагаанд оролцох хүсэлтэй хүүхдүүдэд хүртэл хамааралтай болсон.⁸³ Эмнести Интернэшнлийн судалгаанаас үзэхэд, одоо хэрэгжиж буй энэхүү хориг нь Прэй Прэяаг оруулаад, бусад тусгай хамгаалалттай газар болон ойг хамрах болсон байна. 2020 оны 2 дугаар сард Прэй Лангад болсон үйл явдал хэвлэл мэдээллийн анхаарлыг ихээр татаж, иргэний нийгмийн байгууллагууд буруушааж байсан хэдий ч Байгаль орчны яамнаас орон нутгийн иргэдийн байгаль хамгаалал болон хамгаалалттай бусад ойд тавьсан ижил төстэй хязгаарлалтуудын талаар тодорхой мэдээлээгүй байна. Одоогийн хориг нь Прэй Ланг болон Прэй Прэяа Рокагийн аль алиных нь орон нутгийн иргэдийн байгаль хамгаалах үйл ажиллагаа явуулах эрхэд ямар нөлөө үзүүлэх талаар энэ хэсэгт тоймлон авч үзнэ.

Эмнести Интернэшнлийн ажилтнууд Прэй Лангийн ойг хамгаалахад оролцдог нутгийн уугуул 10 Куй иргэнтэй ярилцлага хийсэн юм. Тэд бүгд Байгаль орчны яамнаас тавьсан хязгаарлалт Прэй Лангийг хамгаалахад маш их саад болж байна гэжээ. Тэдний нэгний хэлснээр:

Хамгийн том чухал асуудлын нэг бол Байгаль орчны яамнаас бидний эргүүл хийх, мод бэлтгэлийн явцыг баримтжуулахад саад хийж байгаа явдал юм. Түүнчлэн, төрийн албан хаагчид үүргээ биелүүлдэггүй байна, мөн бидний өгсөн хууль бус мод бэлтгэлийн талаарх мэдээллийг дарга нартаа мэдээлэхгүй байна. Бид тэдгээр хүмүүс рүү (орон нутгийн Байгаль орчны яам) утасдахад, албаны хүмүүс утсаа ч авдаггүй.⁸⁴

Ярилцлага өгсөн бас нэг хүн ингэж ярихдаа “Байгаль орчны яамнаас бидний ой руу нэвтрэхийг хориглоод байгаа нь л хамгийн том бэрхшээл болоод байна. Биднийг байнга хянаж, мөрдөж байгаа нь бидний ажилд ихээхэн саад учруулдаг”⁸⁵ гэжээ.

Ийм дарангуйлал зөвхөн Прэй Лангаар хязгаарлагдахгүй. Эмнести Интернэшнлийн ажилтнууд Прэй Прэяа Рокагийн Байгаль хамгаалах үйл ажиллагаанд оролцдог нутгийн уугуул голдуу 10 хүнтэй ярилцлага хийв. Прэй Лангийн нэгэн адил, Байгаль орчны яамнаас бие даасан үйл ажиллагаанд нь тавьсан бодит хориг тэдэнд томоохон сорилт болж байв. Байгаль орчны



⁷⁹ Пхуонг Вантха, “8 жил илүү өнгөрчихөөд байхад Чут Ваттигийн аллагад хэн ч хариуцлага хүлээгээгүй байна”, 2021 оны 4 сарын 27, Камбодианесс, cambodianess.com/article/more-than-nine-years-on-no-justice-for-chut-wuttys-murder

⁸⁰ Фак Сеанли ба Игор Коссов, “Талархал хүлээсэн идэвхтэн Прэй Лангийн ойд эргүүл хийж яваад халдлагад өртөв”, 2021 оны 3 сарын 29, Пном Пенний Пост, phnompenpost.com/national/lauded-activist-attacked-while-patrolling-prey-lang-forest

⁸¹ Соёлын үлдэж хоцрохын төлөөх тэмцэл, “ПЛОНИС-ний идэвхтэнийг амийг хөнөөхийг оролдов”, 2016 оны 3 сарын 30. culturalsurvival.org/news/attemptedmurder-prey-lang-community-network-activist

⁸² Эмнести Интернэшнлийн, “Камбож: Прэй Лангийн нутгийн идэвхтэнүүдэд ял оноож байгаа нь байгаль хамгаалагчдад дарангуйлал үзүүлж байна”, 2021 оны 10 сарын 11, amnesty.org/en/latest/news/2021/10/cambodian-environmental-activist-convicted

⁸³ Чиа Сокни, “Өсвөрийн идэвхтэнүүд орон нутгийн ойгоос хөөгдсөний дараа гомдсондоо уйлдаг”, 2021 оны 10 сарын 30, Камбожийн Сэтгүүлчдийн Нэгдсэн Холбоо, cambodianews.com/youth-activists-cry-foul-after-being-turned-away-from-community-forests

⁸⁴ Эмнести Интернэшнлийн Кем Дутаг хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар.

⁸⁵ Эмнести Интернэшнлийн Кен Хуоттой хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар.

БИДНИЙ УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫГ УСТГАЖ БАЙНА

КАМБОЖ: ДАРХАН ЦААЗАТ ОЙ ДАХЬ ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ, ДАРАНГУЙЛАЛ, УГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ

Эмнести Интернэшнл

яамнаас тэднийг ойд нэвтрэхийг хориглосноос болж орон нутгийн иргэдийн байгаль хамгаалах үйл ажиллагаа асар их бэрхшээлтэй тулгарч байгаа тухай ярилцлага өгсөн бүх хүн хэлж байлаа.

Прэй Прэяя Рокагийн идэвхтэнүүд 2021 онд хоёр эргүүл хийсэн боловч Байгаль орчны яамны ажилтнуудаас болгоомжлохын тулд нууцаар, цөөн тоогоор явж эргүүл хийсэн гэжээ. Орон нутгийн идэвхтэнүүд яамныхны үйл ажиллагаанд сэтгэл дундуур байгаагаа илэрхийлээд, тэд мод бэлтгэл дэх өөрсдийн хууль бус ажиллагааг хамгаалахын тулд олон нийтийн оролцоог хязгаарлахыг оролдож байна гэж үзэж байгаагаа илэрхийлсэн байна.⁸⁶

Судалгаанд оролцогчдын нэгний хэлснээр 2016-2018 оны хооронд Байгаль орчны яам болон ППРОНИС хоорондын харилцаа сайн байсан ба ойн гэмт хэргийг мөрдөх асуудлаар байнга хамтарч байсан гэв.

Тэрээр нэмж хэлэхдээ, бид ойг илүү сайн мэддэг, мод бэлтгэлийг баримтжуулж, сэргийлж байсан учраас хэдэн жилийн өмнө бидэнтэй хамтран ажиллаж эхэлсэн гэж би боддог. Хэрвээ бид хамтдаа ажиллах юм бол бид тэднийг мод бэлтгэгчдээс мөнгө авахыг хэзээ ч зөвшөөрөхгүй, бид олуулаа байсан болохоор тэд биднээс эмээдэг байсан⁸⁷ гэв.

2019 оноос эхлээд Байгаль орчны яамтай харилцах харилцаа өөрчлөгдөж, Яам ППРОНИС-ний гишүүдийн өгсөн мод бэлтгэлийн талаарх мэдээлэлд хангалттай хариу өгөхөө больж, зориудаар үл тоомсорлох болжээ. Мөн идэвхтэн гишүүний хэлснээр, “Хамгийн том бэрхшээл бол төрийн албан хаагчид бидэнтэй зүгээр л хамтарч ажиллахгүй, ойг хамгаалах, мод огтлохыг зогсоох талаар ямар ч үүрэг амлалт өгөхгүй байгаа явдал юм.”⁸⁸

Хууль бус мод бэлтгэлийн талаар өгсөн мэдээллийг нь мужийн Байгаль орчны яам үл тоомсорлож байгаад бухимдсан ППРОНИС-ний гишүүд өөрсдийн цуглуулсан мод бэлтгэлийн талаарх нотлох баримтаа Пном Пенн дахь Байгаль орчны яамны төв байранд шууд авчирчээ.⁸⁹ Гэтэл, Пном Пенн дахь Байгаль орчны яам эдгээр асуудлыг багасгах ямар ч арга хэмжээ авсангүй, үнэн хэрэгтээ ППРОНИС Прэй Лангад ППРОНИС-нийхэнд тулгарсантай ижил Байгаль орчны яамныхны хяналтан дор эргүүл хийх хязгаарлалттай нүүр тулж эхэлсэн байна.

Прэй Лангийн тохиолдолтой нэгэн адил, ППРОНИС-ний гишүүдийг эргүүл хийх боломжгүй гэж үзсэн албан ёсны шалтгаан нь тэд орон нутгийн ойн бүлэг эсвэл ТББ-аар албан ёсоор бүртгүүлээгүйтэй холбоотой.⁹⁰ Судалгаанд оролцсон зарим хүмүүсийн хэлснээр Байгаль орчны яамны албан тушаалтнууд “тосгоны оршин суугчид ойгоо хамгаалах эрхгүй”,⁹¹ байгаль хамгаалах бүх ажлыг Яаманд үлдээх нь зүйтэй гэсэн мэдэгдлийг байнга хийдэг гэв.

Байгаль орчны яамны үйл ажиллагаа орон нутгийн иргэдийн ППРОНИС-ний үйл ажиллагаанд оролцоход сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй, тэдний сайн сайхан байдалд ч нөлөөлсөн. Нэг идэвхтэн ярихдаа:

Байгаль орчны яамнаас ойг хатуу хянах болсноор бид ой руу орох боломжгүй болсон нь том асуудал болоод байна. Би бараг жил орчим ой руу орж чадаагүй. Үнэнийг хэлэхэд, ийм нөхцөл ой хамгаалах миний хүслийг үгүй болгож, ер нь цаашид ойгоо хамгаалж чадна гэх итгэл төрөхөө больсон. Энэ нь хүмүүсийг ойгоо хамгаалахаас татгалзах том хүчин зүйл болж байна. Бид энэ бүхнийг Байгаль орчны яаманд үлдээх, эсвэл тэдний дүрэм журмыг дагах ёстой бололтой. Үнэнийг хэлэхэд заримдаа бид оролцохгүй нь дээр, бүх төлбөр, дарамт шахалтуудаас зайлсхийж, бусдад даатгасан нь дээр гэж боддог.⁹²

⁸⁶ Эмнести Интернэшнлийн Нор Дутай хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар, Эмнести Интернэйшинлийн Чан Самбаттай хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар.

⁸⁷ Эмнести Интернэшнлийн Чан Самбаттай хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар.

⁸⁸ Эмнести Интернэшнлийн Нор Дутай хийсэн ярилцлага, 2021 оны 8 сар.

⁸⁹ Эмнести Интернэшнлийн Чан Тидаттай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар, Эмнести Интернэйшинлийн Лин Борамэйтий хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар, Эмнести Интернэйшинлийн Ду Вутитай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар.

⁹⁰ Эмнести Интернэшнлийн Лин Борамэйтий хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар, Эмнести Интернэйшинлийн Ду Вутитай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар.

⁹¹ Эмнести Интернэшнлийн Лин Борамэйтий хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар, Эмнести Интернэйшинлийн Ду Вутитай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар.

⁹² Эмнести Интернэшнлийн Чан Тидаттай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар

ППРОНИС-ний нэг гишүүн нөхцөл байдлыг ингэж тайлбарлалаа:

Одоогийн байдлаар Байгаль орчны яам бидэнд байгаль хамгаалах үйл ажиллагаа явуулах боломжийг олгохгүй байна. Тэд биднийг ойд нэвтрэхийг байнга хориглож, бидэнтэй нилээн дайсагнасан байдалтай харилцдаг. Тэд явуулж буй үйл ажиллагаагаа нуухыг хичээж, хүмүүст мэдэгдэхийг хүсдэггүй бололтой. Прэй Прэяя Рокагаас гадагш гарч буй бүх зам дагуу төрийнхөн хүлээж байдаг боловч мод ачсан машинуудад асуудал тулгардаггүй бололтой байдаг.⁹³

ДОТООДЫН БОЛОН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙГ ЗӨРЧИЖ БҮЙ ХЯЗГААРЛАЛТУУД

Байгаль орчны яамны тусгай хамгаалалттай ойд нэвтрэхийг хориглох бодлого нь Камбожийн хууль тогтоомж болон хүний эрхийн олон улсын эрх зүйтэй шууд зөрчилдөж байна. Прэй Лангийг хамгаалах ажилд оролцдог нутгийн уугуул идэвхтэн Тай эргүүлийн үйл ажиллагааг бодитоор хориглосноос хойш Байгаль орчны яамны ажилтнууд хөндлөнгөөс оролцсон тухай жишээг ингэж яриу: Бид давирхайн модод дээр “Тайрч болохгүй” гэсэн тэмдэг тавихаар ой руу явсан юм. Тэд бидэн дээр ирээд, биднийг дүүргийн цагдаагийн хэлтэст аваачиж, тэдэнтэй байнга хамтран ажиллана, ой руу явахаас өмнө тэднээс зөвшөөрөл авна гэсэн амлалт авахуулсан, мөн ойн албан ёсны бүлэгт биднийг бүртгүүлэх ёстой гэсэн. Түүнээс хойш биднийг маш ихээр дарамталж, хянадаг болсон.⁹⁴

Тайгийн өгсөн тайлбар болох Тай болон түүний нөхөд “ой руу явахаас өмнө үргэлж зөвшөөрөл авах ёстой”, “тэднийг албан ёсны ойн бүлэгт бүртгүүлэх ёстой” зэрэг албаны хүмүүсийн анхааруулгууд нь Байгаль орчны яамны ажилтнуудын 2020 оны 2 дугаар сараас хойш өгсөн мэдэгдлүүдтэй нийцэж байна.

Байгаль орчны яамны албан тушаалтнууд нэгдүгээрт: Камбожийн Эвлэлдэн нэгдэх тухай болон ТББ-уудын тухай хууль (ЭНТББХ), хоёрдугаарт: Тусгай хамгаалалттай газрын тухай хууль гэсэн хоёр өөр хуулийн заалтыг баримталдаг. Уг хоёр хуулийн холбогдох заалтуудад хүний эрхийн олон улсын хууль тогтоомж, стандартуудыг дагуу дүн шинжилгээ хийв. Нэгд, Байгаль орчны яамны зүгээс ПЛОНИС, ППРОНИС зэрэг бүлгүүдийг ойн эргүүл болон байгаль хамгаалах үйл ажиллагаанд оролцохын тулд “бүртгэгдсэн байх ёстой” гэж үзэж байгаа нь 2015 оны 8 дугаар сараас олон улсын болон Камбожийн хүний эрхийн байгууллагуудын хүчтэй шүүмжлэлийн дунд хэрэгжиж эхэлсэн ЭНТББХ-тай холбоотой. Хууль батлагдахаас өмнө тус хуулийг эвлэлдэн нэгдэх эрхэд нийцэхгүй байгааг, орон нутгийн иргэдийн идэвх санаачилгад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дурдаж, ЭНТББХ-иас татгалзахыг Эмнести Интернэшнл уриалж байсан.⁹⁵

ПЛОНИС зэрэг бүлгүүдийг гадуурхах явдлыг зөвтгөхийн тулд байнга иш татагддаг ЭНТББХ-ийн хамгийн маргаантай заалт нь 6-р зүйлд заасны дагуу ТББ болон холбоодыг заавал бүртгүүлсэн байх тухай шаардлага юм. Уг хуульд ТББ, холбоо зэргийг зөв тодорхойлж чадаагүй учир заавал бүртгүүлэх шаардлагыг дур зоргоороо тайлбарлах боломжийг олгосон байна.

ЭНТББХ-д зааснаар, бүртгэлгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол хүлээх хариуцлага нь үйл ажиллагааг хориглох, торгох, гишүүдийг нь эрүүгийн хариуцлага оногдуулах зэрэг болно. Заавал бүртгүүлсэн байх тухай энэхүү журам болон үүнээс үүдэн бүртгэлгүй бүлгүүдийг гадуурхах нь Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон улсын Пактын 22-р зүйлд заасан эвлэлдэн нэгдэх эрхтэй нийцэхгүй юм.

НҮБ-ын тайван жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудлаарх Тусгай илтгэгч “эвлэлдэн нэгдэх эрх чөлөө нь бүртгэгдээгүй нэгдлийг ч мөн хамгаалдаг” гэдгийг онцлоод, аливаа нэг бүртгэлгүй холбоонд нэгдсэн хүмүүс ч аливаа үйл ажиллагаа явуулах, түүний дотор тайван замаар жагсаал цуглаан хийх, оролцох, эрүүгийн хариуцлагад татагдахаас ангид байх зэрэг эрхтэй” гэж мэдэгджээ.

⁹³ Эмнести Интернэшнлийн Ду Вутитай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар.

⁹⁴ Эмнести Интернэшнлийн Тай Чанлитай хийсэн ярилцлага, 2021 оны 9 сар.

⁹⁵ Эмнести Интернэшнл, Камбож: ЭНТББХ-ийн төслийг эргүүлэн татах нь, (Index: ASA 23/1909/2015), 22 June 2015, amnesty.org/en/documents/asa23/1909/2015/en

БИДНИЙ УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫГ УСТГАЖ БАЙНА

КАМБОЖ: ДАРХАН ЦААЗАТ ОЙ ДАХЬ ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ,

ДАРАНГҮЙЛАЛ, УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ

Эмнести Интернэшнл

Тусгай илтгэгч цааш үргэлжлүүлэн:

Бүртгэгдээгүй холбоод хуулийн дагуу эрх тэгш хамгаалуулах, чөлөөтэй үйл ажиллагаа явуулах эрхтэй. Мөн гишүүд нь аюулгүй, ажиллах боломжтой нөхцөлд, ялангуяа эвсэл, холбоо байгуулах нь хүнд сурталтай, захиргааны шийдвэрээр тодорхойлогддог, бүртгэлгүй холбооны үйл ажиллагаанд оролцсон хүмүүст эрүүгийн хариуцлага оногдуулах эрсдэлтэй үед чөлөөтэй үйл ажиллагаа явуулах эрхтэй.⁹⁶

Түүнчлэн НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар ЭНТББХ-ийн заавал бүртгүүлэх журам нь Камбожийн Үндсэн хууль болон хүний эрхийн олон улсын хууль тогтоомжоор баталгаажсан эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хамгаалах тус улсын үүрэг хариуцлагатай нийцэхгүй байна гэж мэдэгджээ.⁹⁷

Байгаль орчны яамнаас ПЛОНИС, ППРОНИС зэрэг бүлгүүд ЭНТББХ-ийн шаардлагыг дагаж мөрддөг гэсэн мэдэгдэл хийсэн нь тус улсын Дотоод хэргийн яамнаас 2015 онд ЭНТББХ-ийг батлагдсаны дараа тус хууль нь орон нутгийн иргэд болон албан бус бүлгүүдэд хамаарахгүй гэж бичгээр гаргасан баталгаатай зөрчилдөж байна.⁹⁸

Эмнести Интернэшнлээс Камбожийн⁹⁹ болон олон улсын¹⁰⁰ хоёр хуулийн фирмийн хийсэн судалгааны дүгнэлтийг нэмж хянасан ба тэд ч ижил дүгнэлтэнд хүрсэн байжээ. ЭНТББХ-д өгсөн тодорхойлолтын дагуу ПЛОНИС-г холбоо, ТББ гэж үзэх шаардлагагүй тул энэхүү асуудал дагуулсан хуулийн бүртгэлийн шаардлагаас чөлөөлөгдөх ёстой. Тус улсын хүний эрхийн үүрэг хариуцлагатай зөрчилдөж бичигдсэн уг маргаантай хуулийн сөрөг нөлөө нь дур зоргоор хэрэгжиж байгаагаараа улам бүр даамжирч байгааг харж болохоор байна.

Хоёрдугаарт, байгаль орчны асуудал хариуцсан албан тушаалтнууд орон нутгийн иргэд, идэвхтэнүүдийг оролцуулахгүй байх явдлыг Камбожийн Тусгай хамгаалалттай газрын тухай хуультай холбогдуулан зөвтгөсөн. Тусгай хамгаалалттай газрын тухай хуулиар Прэй Ланг, Прэй Прэяя Рока зэрэг дархан цаазтай газруудыг бүсчлэн хуваахыг шаарддаг ба тухайн бүс нутаг орон нутгийн иргэдийн нэвтрэхийг зөвшөөрөгдөх хэмжээ нь бүсчлэлээс хамааран харилцан адилгүй байдаг.

Гэсэн хэдий ч өнөөг хүртэл Прэй Ланг болон Прэй Прэяя Рокагийн аль алиныг албан ёсоор бүсчлээгүй байгаа ба хуульд ямар нэгэн “үл хөндөх бүс”-ийн тухай заалт байхгүй (өөрөөр хэлбэл, хэрвээ тухайн газрыг бүсчлээгүй бол Тусгай хамгаалалттай газрын тухай хуулиар бүх тусгай хамгаалалттай газрыг “үндсэн”, эсвэл хориотой бүс гэж үзнэ гэх мэт). Уг хуулийн 12-р зүйлд зааснаар аливаа тусгай хамгаалалттай газрыг бүсчлэх зарчмыг Байгаль орчны яамнаас гаргасан Пракад (дэд журам) тусгасан байх ёстой. Гэтэл одоог хүртэл ийм Прака гараагүй байна. Иймээс, “үндсэн бүс” рүү нэвтрэхийг хориглосон Байгаль орчны яамны албан тушаалтнуудын хязгаарлалтууд нь дотоодын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн үндэслэлгүй юм.

Дотоодын хууль тогтоомжид хүчин төгөлдөр эрх зүйн үндэслэл байхгүй учир Байгаль орчны яамны энэхүү хязгаарлалт нь ИУТЭОУП-ын 21-р зүйлд заасан орон нутгийн иргэдийн тайван жагсаал цуглаан хийх эрхийг зөрчиж байна. 21-р зүйлд “хуульд нийцсэн, ардчилсан нийгэмд үндэсний болон олон нийтийн аюул байдал, нийтийн хэв журам, нийгмийн эрүүл мэнд, ёс суртахуун, эрх, эрх чөлөөг хамгаалах ашиг сонирхолд зайлшгүй шаардлагатай” үед тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлах аливаа хязгаарлалтыг хийхийг шаарддаг. Үндэсний хууль тогтоомжид заасан үндэслэл байхгүй эдгээр хязгаарлалтууд нь хууль ёсны зарчмыг илт

⁹⁶ НҮБ-ын тайван жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн тайлан: 2012 оны 5 сарын 21, UN Doc. A/HRC/20/27, догол мөр 56.

⁹⁷ НҮБ-ын Камбож дахь ХЭДКГ, ЭНТББХ-д хийсэн хүний эрхийн дүн шинжилгээ, 2015 оны 8 сар, 3-р зүйл. cambodia.ohchr.org/-/cambodiaohchr/sites/default/files/ОНCHR_analysis_of_5th_LANGO_Eng.pdf

⁹⁸ Камбожийн Хүний Эрхийн Төв, “КХЭТ Дотоод хэргийн яамнаас ЭНТББХ нь орон нутгийн иргэдийн байгууллага болон албан бус бүлгүүдэд хамаарах эсэх тухай тодруулга авлаа”, 2015 оны 9 сарын 23, cchrcambodia.org/media/files/press_release/575_202crcfme_en.pdf

⁹⁹ Камбожийн хуулийн фирмийн нэрийг нууцлалын болон аюулгүй байдлын шалтгаанаар нууцлав. “Камбожийн ойд нөхөн сэргээлт, хамгаалалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулж буй ТББ-ууд, Нийгэмлэгүүд, орон нутгийн иргэдийн эрх”. 2020 оны 6 сарын 25.

¹⁰⁰ Олон улсын хуулийн фирмийн нэрийг нууцлалын болон аюулгүй байдлын шалтгаанаар нууцлав. “Прэй Лангийн орон нутгийн иргэдийн сүлжээг зохицуулж буй хууль тогтоомжийн үнэлгээ”, 2020 оны 9 сарын 16.

зөрчиж байгаа учир ПЛОНИС болон ППРОНИС зэрэг нөлөөлөлд өртсөн орон нутгийн иргэдийн эрхийг зөрчиж байна.

Түүнчлэн, эдгээр хязгаарлалт нь орон нутгийн иргэдийн нутгийн уугуул иргэд болохынх нь хувьд эдлэх эрхийг нь зөрчсөн явдал юм. ПЛОНИС болон ППРОНИС-нд тулгараад буй хязгаарлалтын тухайд НҮБНУИЭТТ-ын 29.1 дэх хэсэгт “Нутгийн уугуул иргэд өөрсдийн байгаль орчин, газар нутаг, нөөц баялгийнхаа бүтээмжит байдлыг хамгаалах, нөхөн сэргээх эрхтэй. Улс орнууд нутгийн уугуул иргэдэд ийм хамгаалалт, нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулахад нь зориулсан тусламжийн хөтөлбөрийг боловсруулж, аливаа ялгаварлалгүйгээр хэрэгжүүлнэ” гэж заасан байдаг.

26-р зүйлийн 26.1 дэх хэсэгт “Нутгийн уугуул иргэд уламжлалт байдлаар эзэмшиж, оршин сууж, бусад хэлбэрээр эзэмшиж, олж авсан газар, нутаг дэвсгэр, нөөц баялгаа эзэмших эрхтэй” гэж заажээ. Өмнө ЭЗНСЭОУП-д дурдсанчлан, дотоодын хууль тогтоомжид хүчин төгөлдөр үндэслэл байхгүй байхад уугуул иргэдийн эрхэд ийнхүү халдах нь дур зоргийн хэрэг болохын хамт Камбожийн олон улсын хүний эрхийн үүрэг хариуцлагатай зөрчилдөж байна. Түүгээр ч зогсохгүй, хэрэв Байгаль орчны яам эдгээр хязгаарлалтын эрх зүйн үндсийг бүрдүүлэхийн тулд шаардлагатай Пракасыг батлавал энэ нь олон улсын хүний эрхийн хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн байх, тухайлбал, орон нутгийн иргэд, идэвхтэнүүдийн эрхийг шаардлагатайгаас илүүгээр хязгаарлахгүй байх, мөн нөхөн сэргээх боломжтой байх ёстой.

2020 оны 2 дугаар сард Байгаль орчны яамнаас баталсан шинэ бодлогыг нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэдэд зохих ёсоор урьдчилан мэдэгдэлгүй, тэдэнтэй зөвшилцөлгүйгээр хэрэгжүүлжээ. Энэхүү алхам нь НҮБНУИЭТТ-ын 19-р зүйлтэй шууд зөрчилдсөн ба үүнд: “Улс орнууд нутгийн уугуул иргэдтэй тэдний төлөөлөгчдийн байгууллагаар дамжуулан, тэдэнд нөлөө үзүүлж болох хууль тогтоомж, захиргааны арга хэмжээг батлахын өмнө ЧУМЗ-ийг нь авч, зөвшилцөж, хамтран ажиллана” гэжээ.

Байгаль орчны яамны эдгээр хязгаарлалт нь нөлөөлөлд өртсөн нутгийн уугуул иргэд болон байгаль хамгаалагч идэвхтэнүүдийн эрхийг шууд зөрчиж байгаагаас гадна ойн хамгийн сайн хамгаалагчдыг оруулаагүй учир Камбожийн тусгай хамгаалалтай ойгоо үр дүнтэй хамгаалах хүчин чармайлтын үр нөлөөг бууруулж байна.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

4. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Камбож улс тусгай хамгаалалтай ойгоо хамгаалах арга барилаа яаралтай шинэчлэх шаардлагатай болжээ. Эрс өөрчлөлт хийхгүйгээр Прэй Ланг, Прэй Прэйяа Рока зэрэг ойнууд хяналтгүй, хууль бус мод бэлтгэл, өргөн тархсан авлигын улмаас мөхлөө хүлээж, эдгээр ойгоос олон үеийн турш хамааралтай амьдарч ирсэн нутгийн уугуул иргэдийн эрх болон биологийн олон янз байдал, уур амьсгалыг гамшигт үр дагаварт хүргэж байна. Сүүлийн хоёр жилийн хугацаанд Камбожийн албан тушаалтнууд үнэт ой модоо хамгаалахыг зорьж байсан нутгийн уугуул иргэд болон байгаль хамгаалах идэвхтэнүүдийг хавчин гадуурхаж, дарамталж байсан атлаа хууль бус мод бэлтгэгчдэд ой модыг ямар нэгэн саадгүйгээр устгах боломжийг олгосон. Прэй Ланг, Прэй Прэйяа Рокагийн ойгоос амьжиргаа, соёл, ёс уламжлал сайн сайхан байдлын хувьд хамааралтай Куй иргэдийн өвөг дээдэс нь болсон ойг эрх мэдэлтнүүд хамгаалж чадахгүй байгаа нь тэдний эрхийг зөрчиж байна.

Дэлхий нийтээр нутгийн уугуул иргэд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн тэргүүн эгнээнд өртөх нь түгээмэл. Тэд өөрсдийн амьжиргаа, соёлын онцлог нь хамаарч байдаг байгаль орчин, уламжлал газар нутагтайгаа нягт харилцаа холбоотой хүмүүс юм.¹⁰¹ Камбожийн эрх мэдэлтнүүд нутгийн иргэд болон уугуул иргэдийг байгаль хамгаалах бодлого, үйл ажиллагаанаас шахан гаргахын оронд Куй иргэдийн Прэй Ланг, Прэй Прэйяа Рока зэрэг ой модтой холбоотой өвөрмөц мэдлэг, харилцаа холбоог хүлээн зөвшөөрч, байгаль хамгаалах бүхий л бодлого, үйл ажиллагаагаа нөлөөлөлд өртсөн уугуул иргэдийн ЧУМЗ-д үндэслэн хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Хууль бус мод бэлтгэлийг хяналтгүй орхихыг зогсоохын тулд Камбожийн байгаль орчны асуудал хариуцсан албан тушаалтнууд ПЛОНИС, ППРОНИС зэрэг бүлгүүдийг ойн эргүүл хийхийг хориглосон хууль бус хоригоо цуцалж, Прэй Ланг болон Прэй Прэй Рока зэрэг тусгай хамгаалалттай ойд хяналт тавих, мөрдөн шалгах, хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох зорилгоор ойд нэвтрэх боломжийг орон нутгийн ой хамгаалах идэвхтнүүдэд тодорхой, хоёрдмол утгагүйгээр олгох ёстой.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

¹⁰¹ Жишээ болгож, НҮБ-ын Нутгийн уугуул иргэдийн эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн тайлан: Норвег, Швед, Финлянд дахь Сампи дүүргийн Сами хүмүүсийн нөхцөл байдал. 2011 оны 6 сарын 6, НҮБ-ын баримт бичиг. А/HRC/18/35/Add.2; НҮБ-ын Нутгийн уугуул иргэдийн эрхийн асуудлаарх Тусгай илтгэгчийн тайлан, 2017 оны 11 сарын 1 НҮБ-ын баримт бичиг. А/HRC/36/46, догол мөр 6-7

ЗӨВЛӨМЖ

КАМБОЖИЙН ЗАСГИЙН ГАЗАРТ

Эмнести Интернэшнлээс Камбож улсад хандан дараах зөвлөмжийг өгч байна:

- Прэй Ланг, Прэй Прэйяа Рока болон Камбожийн тусгай хамгаалалттай бусад ойд орон нутгийн иргэдийн эргүүл хийхийг бодитоор хязгаарласан хоригийг олон нийтэд нээлттэйгээр, хоёрдмол утгагүйгээр цуцлах,
- Прэй Ланг, Прэй Прэйяа Рока болон тусгай хамгаалалттай бусад ойд нутгийн уугуул иргэд холбогдох эрх мэдэлтнүүдээс урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр, ямар ч үед ойд нэвтрэх боломжтой гэдгийг олон нийтэд ил тод, хоёрдмол утгагүйгээр тодорхой зарлах,
- ПЛОНИС болон ППРОНИС зэрэг орон нутгийн идэвхтэнүүдийн албан бус бүлгүүд холбогдох эрх мэдэлтнүүдээс урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр Прэй Ланг, Прэй Прэйяа Рока болон тусгай хамгаалалттай бусад ойд хамгааллын үйл ажиллагаа (эргүүл хийхийг оруулаад) явуулах эрхтэй гэдгийг олон нийтэд нээлттэй, хоёрдмол утгагүйгээр зарлах,
- Байгаль орчны идэвхтэн, хамгаалагч нарыг дарамтлах, сүрдүүлэхээ зогсоож, байгаль хамгаалахаар ажиллаж буй бүх хүний эрх хамгаалагчдыг хамгаалж, үйл ажиллагааг нь дэмжих явдлыг баталгаажуулах,
- Байгаль хамгаалагчдад халдсан хэргийг шударга, хараат бус, ил тод мөрдөн шалгах, буруутай этгээдүүдэд дотоодын болон олон улсын стандартын дагуу хариуцлага тооцох,
- Байгаль орчны яамны албан тушаалтнуудын, мөн Прэй Ланг, Прэй Прэйяа Рокагийн болон түүний эргэн тойронд, Камбожийн улс даяарх тусгай хамгаалалттай бусад ойн бүс дэх цагдаагийн ажилтнуудын авлигын хэргийг шударга, хараат бус, ил тод мөрдөн шалгаж, дотоодын болон олон улсын хэм хэмжээний дагуу буруутай этгээдүүдтэй бүрэн хариуцлага тооцох,
- Уугуул иргэдийн эрхийг хөндөж болзошгүй бүхий л санаачилга (хууль, бодлого, хөгжлийн төслүүд, байгаль хамгаалах болон уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг санал санаачилга зэрэг) зөвхөн тэдний ЧУМЗ-ийг авсаны дараа хэрэгжих явдлыг баталгаажуулах,
- ЭНТББХ-ийг хүчингүй болгох буюу шинэчлэн найруулж, олон улсын хүний эрхийн хууль тогтоомж, стандартад нийцүүлэх, тухайлан холбоод болон ТББ-ыг заавал бүртгүүлсэн байх журмыг хүчингүй болгох,
- Тусгай хамгаалалттай ойн орчимд үйл ажиллагаа явуулж буй бүх ЭЗГК болон “дахин ойжуулах” шударга, хараат бус шалгалт явуулж, хууль бус мод бэлтгэл дэх томоохон компаниудын оролцоог мөрдөн шалгах,
- Нутгийн уугуул, Овгийн хүмүүсийн тухай Дэлхийн Хөдөлмөрийн Байгууллагын 169-р конвенцид нэгдэн орох.

OH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН


БИДНИЙ УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫГ УСТГАЖ БАЙНА
КАМБОЖ: ДАРХАН ЦААЗАТ ОЙ ДАХЬ ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ,
ДАРАНГУЙЛАЛ, УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ
Эмнести Интернэшнл


**ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ НЬ
ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨӨХ ДАЯН
ДЭЛХИЙН ХӨДӨЛГӨӨН БӨГӨӨД
НЭГ ХҮНД ТОХИОЛДОХ ШУДАРГА
БУС ЯВДАЛ Ч БИД БҮГДЭД
ХАМААРАХ АСУУДАЛ ЮМ.**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Холбоо барих

 info@amnesty.org
mongolia.amnesty@gmail.com

 +44 (0)20 7413 5500
+976 7000 4708

 www.facebook.com/AmnestyGlobal
[www.facebook.com/Amnesty International](http://www.facebook.com/AmnestyInternational)
Mongolia - Монголын Эмнести Интернэшнл

 @AmnestyOnline

БИДНИЙ УЛАМЖЛАЛ, ЁС ЗАНШЛЫГ УСТГАЖ БАЙНА

КАМБОЖ: ДАРХАН ЦААЗАТ ОЙ ДАХЬ ХУУЛЬ БУС МОД БЭЛТГЭЛ, ДАРАНГУЙЛАЛ, УУГУУЛ ИРГЭДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЛ – ЭМНЕСТИ ИНТЕРНЭШНЛ

Камбож улс 2001-2020 оны хооронд бараг 2.5 сая га модон бүрхэвчээ алдсан байна. Хууль бус мод бэлтгэл нь тус улсын үлдсэн ойн санд заналхийлэх болов. Энэ нь биологийн олон янз байдал, уур амьсгалд учруулж буй, бодит аюулаас гадна нутгийн уугуул иргэдийн соёл, хүний эрхэд ноцтой үр дагавар учруулж байна.

Энэхүү тайланд Камбожийн эрх баригчдын үйл ажиллагаа Куй иргэдийн эрхийг хэрхэн зөрчиж байгаа, мөн тэдний Прэй Ланг, Прэй Прэйяа Рока дахь ойг хамгаалах оролдлогод хэрхэн саад учруулж байгааг баримжтуулсан болно.

Зайнаас тандан судлах одоогийн эх сурвалжийг ашиглан хийсэн дүн шинжилгээгээр 2021 онд дээрх тусгай хамгаалалттай газруудын дор хаяж 6,271 га талбайн (8,784 хөл бөмбөгийн талбайтай тэнцэх хэмжээтэй газар) ойг устгасан байна. Нэмэлт мэдээлэл авах боломжууд бий болсноор ой устгалын талаарх илүү их мэдээлэл олдох магадлал өндөр байна. .

Тус улсын эрх бүхий албан тушаалтнууд хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлж, зохистой арга хэмжээ авах замаар Нутгийн уугуул иргэдийн эрхийг хамгаалах үүргээ биелүүлж чадахгүй байна. Гэтэл үүнээс ч дор зүйл байна. Ойн үнэт нөөцийг хамгаалах үүрэгтэй төрийн албан хаагчид эсрэгээрээ ойн устгалаас ашиг олох явдал түгээмэл гарах болжээ. Камбожийн Байгаль орчны яам болон цагдаагийн байгууллагад үүрлэсэн авлига нь хууль бусаар бэлтгэсэн модны наймааг улам гааруулж, тус улсын онцгой ач холбогдол бүхий ойн сан бүхий зарим газруудыг устаж үгүй болох эрсдэлд оруулж байна.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ИНДЕКС: ASA 23/5183/ 2022
2022, НЭГДҮГЭЭР САР
ХЭЛ: АНГЛИ
amnesty.org

ЭМНЕСТИ
ИНТЕРНЭШНЛ

